



Уур амьсгалын өөрчлөлт, түүнд дасан зохицохуй

НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

“Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төсөл

Уур амьсгалын өөрчлөлт, түүнд дасан зохицохуй

НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2026

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНД ДАСАН ЗОХИЦОХУЙ

Бэлтгэсэн: З. Баасансүрэн
Д. Доржханд
Хянан тохиолдуулсан: Э. Лхагважаргал
Зөвлөх: Л. Баян-Алтай
Дизайнер: Л.Лхагвачимэг

АГУУЛГА

Өмнөх үг	4
Нэр томъёоны тайлбар	5
Сэдэв 1. Уур амьсгалын өөрчлөлт ба иргэдийн оролцоо	7
1.1 Цаг агаар ба уур амьсгал	8
1.2 Уур амьсгалын өөрчлөлт Монголд	9
1.3 Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь	10
1.4 Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бид юу хийж чадах вэ?	11
1.5 Мод тарихын ач холбогдол	13
Сэдэв 2. Ойн ач холбогдол	15
2.1 Мод ба ой	16
2.2 Монгол орны ойн сан	17
2.3 Налайх дүүргийн газар зүйн бүтэц	18
2.4 Налайхын нөхцөлд тохиромжтой ногоон байгууламж	21
Сэдэв 3. Мод тарих аргачлал	23
3.1 Хашаандаа тарих модоо хэрхэн сонгох вэ?	24
3.2 Мод тарих аргачлал	25
3.3 Мод тарихад тохиромжтой үе	26
3.4 Мод тарих дараалал	27
3.5 Мод тарихад анхаарах зүйлс	28
Сэдэв 4. Өрхийн нөхцөлд тарихад тохиромжтой модод	31
4.1 Үр жимсээ хурдан өгөх жимсний модод	32
4.2 Хурдан ургалттай чимэглэлийн модод	37
4.3 Амьд хашлагатай болоход хамгийн тохиромжтой сонголтууд	40
4.4 Амьд хашлага хийх аргачлал	41
Сэдэв 5. Модноос ашиг хүртэх боломжууд	43
5.1 Модны суулгац үржүүлж худалдаалах боломж	44
5.2 Жимсний модноос ашиг хүртэх боломж	45
5.3 Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих төслүүд	47
5.4 Төрөөс хэрэгжүүлж буй санаачилгад нэгдэж, урамшуулалд хамрагдах боломж	48
Хавсралт-1, 2: Мод тарьсан тэмдэглэл, Мод арчилгааны хуанли	51
Ашигласан ном зүй	53

ӨМНӨХ ҮГ



Өнөөдөр уур амьсгалын өөрчлөлт нь хүн төрөлхтөнд тулгарч байгаа нэг том бэрхшээл болжээ. Монгол Улс нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр нэрвэгдэж буй улсын нэг билээ. Хүүхдийг Ивээх Сан “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийг БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр нийслэлийн Налайх дүүрэгт 2024 оноос хэрэгжүүлж байна.

Налайх дүүрэг бол өвлийн улиралд агаарын чанар хамгийн мууд тооцогдох бүсүүдийн нэг юм. Мөн хөрсний элэгдэл нэмэгдэж, цөлжилт эрчимжиж байгаа нь байгаль орчин, иргэдийн эрүүл мэндэд бодит эрсдэл учруулж байна. Түүнчлэн тус дүүрэг нь Улаанбаатар хотын ундны усны эх үүсвэртэй ойрхон байрладаг тул ногоон төгөл, ойжуулалтын ажил зайлшгүй шаардлага бий болгожээ. Тиймээс бид “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийн хүрээнд тус дүүрэгт хүүхэд багачууд, иргэдийн оролцоотойгоор ойн төгөл байгуулах, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх хүүхэд залуус, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулахад дэмжлэг үзүүлэхийг зорьж байна.

Энэхүү гарын авлага нь “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийн үр шимийг хүртэгчдэд уур амьсгалын өөрчлөлтийг танин мэдэж дасан зохицох, даван туулах мэдлэгийн хөтөч болно хэмээн найдаж байна.

Налайх дүүрэгт амжилттай хэрэгжиж буй “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж буй дүүргийн ИТХ-ын дарга Н.Мандуул, ИТХ-ын төлөөлөгч, Байгаль орчин ногоон хөгжлийн хорооны дарга Т.Батсүх нарт талархал илэрхийлье.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Л. Баян-Алтай

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР:

ЦАГ АГААР - Тухайн газар орны богино хугацааны доторх агаарын төлөв байдал

ЦАГ УУР - Агаарын үзэгдэл, элементүүдийг судалдаг шинжлэх ухааны салбар

УУР АМЬСГАЛ - Цаг агаарын олон жилийн дундаж горим

УУР АМЬСГАЛЫН БҮРДҮҮЛЭГЧ ХҮЧИН ЗҮЙЛ - Тухайн газар орны уур амьсгалыг тодорхойлогч 1) газрын байдал буюу өргөрөг 2) гадаргын өндөр 3) хотгор гүдгэрийн рельефийн байдал 4) далайн урсгал 5) агаарын орчил урсгал зэргийг хэлнэ.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ - Хүлэмжийн хийнээс үүдэж дэлхийн уур амьсгалын тогтолцоонд гарч буй нийт өөрчлөлт (Өөрчлөлтийг наад зах нь 35-50 жил, түүнээс дээш хугацаагаар тооцно)

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ - Цаг агаарын эрс тэс үзэгдэл, гамшигт нөхцөл байдал, далайн түвшний нэмэгдэлт, биологийн олон янз байдлын доройтол, хоол хүнс, усны аюулгүй байдал зэрэг уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн өнөөгийн тулгамдаж байгаа болон цаашид тулгарч болзошгүй эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаа

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ СААРУУЛАХ - Хүлэмжийн хийн ялгарлыг нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх, улмаар бууруулах, эдгээр хийг агаар мандлаас зайлуулах нүүрстөрөгч шингээгчийг нэмэгдүүлэх зорилго бүхий засгийн газар, бизнес эрхлэгчид, хүмүүсийн авч буй арга хэмжээ

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨЛЛИЙГ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАР - Тухайн орон нутаг болон байгаль орчны уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг урьдчилан таамаглах, сэргийлэх, зохицуулах, тэдгээрээс үүдэх хохирлыг багасгах, анхны цочролын дараа шаардлагатай тохиолдолд нөхөн сэргээх, өөрчлөх чадвар

ЭРС ТЭС УУР АМЬСГАЛ - Тухайн газар нутагт жилийн туршид температур болон цаг агаарын үзэгдлүүдийн хэлбэлзэл хэт өндөр, хурц байхыг хэлнэ.

АМЬДРАХ ОРЧИН - Тухайн амьд биеийн амьдрахад шаардлагатай нөхцөл (хоол хүнс, ус, оромж) бүрдсэн байгалийн орчин.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ - Ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээг хангах чадварт сөргөөр нөлөөлөхгүйгээр өнөөгийн хэрэгцээг хангах хөгжлийн хэв маяг.

ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛ - Хүмүүст байгаль орчны асуудлууд болон тэдгээрийн шийдлийн талаарх мэдлэг, чадвар, хандлага, оролцоог олгоход чиглэсэн тасралтгүй үйл явц юм.

ЭКОЛОГИ - Амьд биес, тэдгээрийн хүрээлэн буй орчин (амьд ба амьгүй) хоорондын харилцан үйлчлэл, хамаарлыг судалдаг шинжлэх ухаан.

ЭКОЛОГИЙН ТЭНЦВЭР - Экосистем дэх амьд биесийн тоо, тэдгээрийн харилцаа, бодисын эргэлт харьцангуй тогтвортой байх төлөв.

ЭКОСИСТЕМ - Өөр хоорондоо тэжээлийн хэлхээгээр холбогдсон бүх амьд бие, тэдгээрийн бодисын солилцоо энергийн хувиралд оролцох орчин тойрны амьгүй бүрэлдэхүүн хэсгүүдийн нэгдмэл тогтолцоо

ДЭЛХИЙН ДУЛААРАЛ - Дэлхийн хуурай газар, далайн гадаргуу орчмын агаарын дундаж хэм ихсэх үзэгдэл (ихэвчлэн хүлэмжийн хийн нөлөөгөөр)

ХҮЛЭМЖИЙН ХИЙ - Нарнаас ирэх богино долгионт цацрагийг нэвтрүүлэх боловч дэлхийн гадаргаас ялгарах урт долгионт цацрагийг гадагш гаргахгүй тогтоон барьдаг хийнүүдийг хэлнэ. Нүүрсхүчлийн хий, метан, азотын исэл, усны уур, гадарга орчмын озон, гидрофторт нүүрстөрөгчүүд, перфторт нүүрстөрөгчүүд, гексафторт хүхэр зэрэг хийнүүд нь дэлхийн гадаргаас гарч буй дулааныг тогтоон барьдаг. Өөрөөр хэлбэл, нарны гэрлийг нэвтрүүлж дамжуулах боловч доторх дулааныг гадагш нэвтрүүлдэггүй шилтэй адил төстэй үүрэгтэй.

БАЙГАЛЬ ОРЧНЫ БОХИРДОЛ - Хүний үйл ажиллагааны нөлөөгөөр агаар, ус, хөрсөнд хортой бодис, бохирдол нэвтэрч, экосистемийн тэнцвэрт байдал алдагдах.

ДААЦ - Тухайн орчны нөөц бололцоонд тулгуурлан, уг орчинд тогтвортой оршин амьдарч чадах тухайн зүйлийн популяцийн дээд хэмжээ.

ЦӨЛЖИЛТ - Үржил шимтэй газар нутаг уур амьсгалын өөрчлөлт болон хүний зохисгүй үйл ажиллагааны (хэт их бэлчээр, ой модны устгал) нөлөөгөөр цөл, цөлөрхөг газар болон хувирах үйл явц.

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ - Дэлхий дээрх амьдралын бүх хэлбэрүүдийн (ген, зүйл, экосистем) ялгаатай ба баялаг байдал.

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ХОМСДОЛ - Амьтан, ургамлын зүйлүүд устаж, амьдрах орчин нь сүйдсэнээс дэлхийн амьдралын олон янз байдал буурах үйл явц.

БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ - Байгалийн нөөц (ус, хөрс, ой, ан амьтан)-ийг ухаалаг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн цогц арга хэмжээ.

НӨХӨН СЭРГЭЭЛТ - Хүний үйл ажиллагаа болон байгалийн гамшгийн улмаас сүйдсэн буюу доройтсон экосистемийг эргүүлэн хэвийн байдалд оруулах үйл ажиллагаа.

Уур амьсгалын
өөрчлөлт ба
иргэдийн
оролцоо



1.1 ЦАГ АГААР БА УУР АМЬСГАЛ

Цаг агаар (Weather) бол тодорхой цаг хугацаа (богино)-н дахь тодорхой газар нутгийн агаар мандлын нөхцөл байдал юм. Өөрөөр хэлбэл, богино хугацааны температур, салхи, үзэгдэл, чийг, даралт, үлшил, алсын бараа зэрэг олон элементүүдээр тодорхойлогдоно. Харин уур амьсгал (Climate) гэдэг нь тодорхой газар нутгийн удаан хугацааны төлөв байдлын агаарын дундаж юм. Цаг агаарын төлөв байдлын элементүүдийн 30-аас дээш жилийн дундаж үзүүлэлт буюу давтагдал, өөрчлөлтийг харгалзаж тодорхойлно. Уур амьсгалыг тодорхойлох гол үзүүлэлтүүдэд температур, хур тунадас, салхины хурд болон чиглэл орно.

Уур амьсгалын өөрчлөлт

Температур болон цаг агаарын төлөв байдал дахь урт хугацааны өөрчлөлтийг уур амьсгалын өөрчлөлт (Climate Change) гэнэ. Уур амьсгалын өөрчлөлтийн гол шалтгаан нь хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн хурдацтай өсөлттэй холбоотой.

Хүний үйл ажиллагаа ялангуяа, малтмал түлш, шатах тослох материалын шаталт, үйлдвэрлэл, мал аж ахуй, ойн доройтол болон газрын ашиглалт зэргээс үүдэн агаар мандал дахь хүлэмжийн хийн агууламж тасралтгүй нэмэгдэж байна.

Хүлэмжийн хийн төрлүүд	Эх үүсвэр
Нүүрсхүчлийн хий	Түлшний шаталт, цахилгаан станц, үйлдвэр, онгоц, автомашин
Метан	Мал аж ахуй, цагаан будаа тариалалт, хог хаягдал
Азотын исэл	Хөрс боловсруулалт, химийн үйлдвэр, онгоц, автомашин
Гадарга орчмын озон	Газрын гадарга орчимд автомашин, цахилгаан станц, уурын зуух зэргээс ялгарсан бохирдуулах бодисууд дулаан, нартай өдөр урвалд орсноор үүснэ.

Хүлэмжийн хийнээс гадна ой модыг устгах, агаарын бохирдол, далайн бохирдол зэрэг хүний буруутай үйл ажиллагааны үр дагавар нь уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж байна. Үүний үр дүнд, дэлхийн дулаарал эрчимжиж, цаашлаад уур амьсгалын тогтолцоонд томоохон өөрчлөлтүүд гарч байна.

Дэлхийн дулаарал

Дэлхийн дулаарал гэдэг нь дэлхийн хуурай газар, далайн гадаргуу орчмын агаарын дундаж температур нэмэгдэх үзэгдэл юм. Дэлхийн дулаарлын улмаас далайн усны төвшин, цаг уурын ноцтой үзэгдэл олширч, хур тунадасны хэмжээ өөрчлөгддөг. Энэ нь хөдөө аж ахуй, мөсөн гол, мөнх цасны хэмжээ, амьтан, ургамлын төрөл зүйлд сөргөөр нөлөөлж, гамшгийн хэмжээнд хүргээд байна. 19 дүгээр зуунтай харьцуулахад агаар мандал дахь хүлэмжийн хийн хэмжээ ойролцоогоор 50 хувиар нэмэгдэж, дэлхийн дундаж температур 1.2°C орчим өссөн байна.

1.2 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ МОНГОЛД

Монгол Улс нь газар зүйн байрлал болон эрс тэс уур амьсгалаас шалтгаалан дэлхийн дундажтай харьцуулахад 2-2.5 дахин хурдтай дулаарч байгаа тул уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг, өртөмтгий улс орнуудын нэгд тооцогдож байна. Монгол орны жилийн дундаж температур сүүлийн 80 гаруй жилийн хугацаанд 2.25°C-аар нэмэгдсэн нь дэлхийн дунджаас даруй 2-3 дахин хурдан дулаарч байна гэсэн үг юм.

Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар

Ган, зуд: Уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж зуд, гангийн давтамж ойртсон. Тухайлбал, 2023-2024 оны зуднаар 7.4 сая мал хорогдож, улс орны эдийн засагт 1.3 их наяд төгрөгийн хохирол учирсан байна.

Байгалийн гамшиг: Гэнэтийн үер, хүчтэй шороон болон цасан шуурганы давтамж нэмэгдэж байгаа нь дэд бүтэц болон иргэдийн амьжиргаанд эрсдэл учруулж байна.

Цөлжилт: Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 76% гаруй нь ямар нэг хэмжээгээр цөлжилт, газрын доройтолд өртөөд байна.


Усны нөөц: Мөнх цэвдэг хайлж, гол горхи, нуур цөөрөм ширгэж байгаа нь усны хомсдол үүсгэж байна. Энэ нь ялангуяа уул уурхай болон хөдөө аж ахуйн салбарт том сорилт болж байгаа юм.

Идэш тэжээлийн хомсдол: Ургамлын бүрхэвч өөрчлөгдөж, бэлчээрийн шимт чанар муудсанаар зэрлэг амьтад болон мал сүргийн идэш тэжээл хомсдож байна.

Эдийн засгийн уналт: Судалгаагаар агаарын температур 1°C-аар нэмэгдэх тутам ДНБ-ий өсөлт 0.48 хувиар саарах хандлагатай байдаг.

Шилжилт хөдөлгөөн: Ган, зудын улмаас амьжиргаагүй болсон малчид хот суурин газар руу ихээр шилжин суурьшиж байгаа нь “уур амьсгалын дүрвэгсэд”-ийн тоог нэмэгдүүлж, Улаанбаатар хотын хүн амын төвлөрөл, агаар, хөрсний бохирдлыг улам хурцатгаж байна.

Эрүүл мэнд: Халуун өдрүүдийн тоо нэмэгдэж, тоос шороо, агаарын бохирдол ихэссэнээр зүрх судас, амьсгалын замын өвчлөл болон хачигт халдварт өвчний эрсдэл нэмэгдэх болсон.



© Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах газар

1.3 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ НЬ

Монгол Улс уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэхийн тулд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж байна. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн нь 2030 он хүртэл дор хаяж нэг тэрбум мод тарьж ургуулах зорилготой. Энэ бол ойн нөөцийг нэмэгдүүлэх төдийгүй амьдрах орчноо хамгаалж, ирээдүй хойчдоо ногоон ирээдүй өвлүүлэх үндэс суурь юм.

Монгол Улсын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлт, нөлөөллийг бууруулах, дасан зохицох чиглэлийн судалгаа, шинжилгээ, тэдгээрийн үр дүн тун боломжийн түвшинд хүрч, бүх нийтээр бүх түвшинд хүлээн зөвшөөрч, тодорхой хууль эрх зүйн орчин бүрдсэн. Мөн НҮБ руу холбогдох судалгаа шинжилгээ, томоохон хэд хэдэн тайлан, илтгэлүүдийг илгээж олон улсын өмнө хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсээр байгаа хэдий ч уур амьсгалын өөрчлөлтийн боловсролыг бүх нийтийн болгох тал дээр бусад орнуудтай харьцуулахад харьцангуй хоцрогдолтой байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврууд нийгэм эдийн засаг, байгаль орчинд гүнзгий нөлөөлж, амьдралын хэв маяг, амьжиргааны түвшин, улс орны хөгжил дэвшилд бодитойгоор нөлөөлж буй өнөө үед уур амьсгалын өөрчлөлтийн боловсролд анхаарлаа хандуулж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох мэдлэг, чадвар, хандлагыг иргэн бүр өөртөө бий болгох нь үр хойчдоо үлдээх үнэт өв юм.

Монгол Улс бол “Залуусын орон” гэгддэг. Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн ихээр өртөж байгаа хөгжиж буй орнуудын нэг. Уур амьсгалын өөрчлөлт бодит аюул болж, байгалийн гамшгийн давтамж нэмэгдэж байгаа өнөө үед хүүхэд, залуусын ирээдүй мөн адил эрсдэлд орж байна. Тиймээс уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь чухал байна.

Бидний өвөг дээдэс энэ асуудлын талаар мэдэх ч үгүй өнгөрсөн, харин ирээдүй хойч үеийнхэн шийдвэрлэнэ гэж хүлээвэл хэтэрхий оройтсон байх болно. Тиймээс бид өнөөдрөөс эхлэн өөрсдийн хүүхдүүд, тэдний ирээдүйн төлөө ӨӨРЧЛӨЛТИЙГ ӨӨРӨӨСӨӨ ЭХЛҮҮЛЭХ нь чухал юм. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход иргэдийн оролцоо маш чухал. Иргэд нэгдэж, өдөр тутмын амьдралдаа энгийн өөрчлөлтүүдийг хийж, оролцоогоо нэмэгдүүлснээр орон нутгийн түвшинд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлыг шийдвэрлэх бүрэн боломжтой. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хамгийн энгийн алхмуудын нэг нь мод тарих юм.

Хүн бүр байгаль дэлхийгээ хайрлан хамгаалж, мод тарьж, өдөр тутмын амьдралдаа зөв дадал хэвшүүлэх нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодит алхам бөгөөд байгальд ээлтэй амьдралын хэв маягийг бий болгох үндэс юм.

Бид нийслэлийн Налайх дүүргийн нутаг дэвсгэрт амьдарч буй нийт оршин суугчийг уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хүчин чармайлтад нэгдэж, мод тарьж, байгальдаа ээлтэй амьдрахыг уриалж байна. Та бид хамтдаа уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох замаар хариу арга хэмжээ авч, Тогтвортой Хөгжлийн Зорилгод хүрэх хүчин чармайлтаа эрчимжүүлэх боломжтой.

1.4 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭСРЭГ БИД ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

Бид өдөр тутмын амьдралдаа зөв дадал бий болгож, байгальдаа ээлтэй амьдрах нь чухал юм. Энэ нь зөвхөн байгаль орчныг хамгаалаад зогсохгүй, эдийн засаг, нийгмийн урт хугацааны үр өгөөж бий болгодог. Тиймээс бид дараах гурван алхмыг зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгтэй.



Суралцах

Уур амьсгалын өөрчлөлтийн талаар үнэн зөв мэдээлэл авч, түүний үр дагавар, дасан зохицох арга замын талаар мэдлэгээ дээшлүүлэх.



Өөрчлөлтийг өөрөөсөө эхлүүлэх

Өдөр тутмын амьдралын хэв маяг, дадлаа байгальд ээлтэйгээр өөрчлөх, байгальд ээлтэй амьдралын хэв маягийг бий болгох, сурталчилах.



Дасан зохицох

Үүсэж болох эрсдэлт нөхцөл, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлж, хариу арга хэмжээ авахад бэлэн байх.

Бидний авч хэрэгжүүлэх энгийн алхмууд

- Гар утсаа 100% цэнэглэсний дараа ашигладаг байх.
- Ашиглахгүй үедээ цахилгааны залгууруудыг салгах, унтраах.
- Ашиглалтын хугацаа нь дууссан, тогны зарцуулалт өндөртэй хөргөгч, электрон бараанаас татгалзах.
- Усыг зөв ашиглах, дахин ашиглах. (Автомашиньг саарал усаар угаах г.м)
- Өрх бүр хашаандаа болон нийтийн талбайд мод тарьж, арчилж, ургуулах.
- Явган болон дугуйгаар явах, эсвэл нийтийн тээврээр зорчиж нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмрээ оруулах.
- Аялалд гарахдаа нэг удаагийн хэрэгсэл, хуванцраас татгалзаж, байгальд ээлтэй сонголтуудыг хийх.
- Зайлшгүй шаардлагагүй зүйл худалдан авахгүй байх, хэрэггүй зүйл худалдан авч хог хуримтлуулахаас зайлсхийх.
- Хог хаягдлыг зориулалтын саванд ангилан хаяж хэвших, дахивар бүтээгдэхүүнийг борлуулах.
- Нөөшлөгч болон будагч бодис, химийн найрлагатай хүнснээс татгалзаж, хүнсний хаягдлыг багасгах.

Жилд багадаа 5 мод тарьж, арчилж ургуулах замаар хүрээлэн буй орчноо ногоон болгоход хувь нэмрээ оруулах.

Иргэдийн оролцоо

Мод тарих ажилд иргэдийн оролцоо маш чухал бөгөөд олон талын ач холбогдолтой. Бид хамтдаа мод тарьснаар агаарын чанарыг сайжруулж, нүүрсхүчлийн хийн хэмжээг бууруулж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад тусална. Мод нь хөрсний бохирдлыг багасгаж, шимт чанарыг сайжруулснаар эрүүл орчин бүрдүүлдэг.

Мод тарих ажилд иргэд идэвхтэй оролцсоноор цагаа зөв боловсон өнгөрүүлэх, байгальтайгаа ойр байж, стрессээ тайлах боломжтой.

Мод тарьсны дараа арчилгаа нэн чухал бөгөөд мод ургуулах нь тууштай хөдөлмөр шаардсан ажил юм. Хүн өөрийн тарьсан модоо хайрлаж, арчилж, ургуулахыг хүсдэг. Тиймээс иргэдэд тарьсан модыг нь эзэмшүүлснээр тухайн модны ургалт, амьдрах чадварыг баталгаажуулдаг.

1.5 МОД ТАРИХЫН АЧ ХОЛБОГДОЛ

Мод тарих нь байгаль орчныг хамгаалаад зогсохгүй иргэдийн экологийн боловсролыг нэмэгдүүлэх, цаашлаад амьжиргааны эх үүсвэр бий болгоход чухал ач холбогдолтой.



Орчны тоосжилтыг
бууруулна.



Уур амьсгалын
өөрчлөлтийг сааруулна.



Агаар цэвэршүүлнэ.



Орчны дуу шуугианыг
багасгана.



Хөрсний элэгдлийг
бууруулна.



Хүний сэтгэл санааг
тайвшруулдаг.

Ой мод нь хуурай газрын бүх амьтан, ургамлын 80%-ийн амьдрах орчин болдог. Гэвч өнөөдөр хүний хэрэгцээг хангахын тулд 5,000 гаруй нэр төрлийн ойн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэж байна. Үүний үр дүнд дэлхийн ойн нөөц жил бүр дунджаар 0,6 хувиар буурч байна гэсэн судалгаа бий.

Хүний зүй бус, хариуцлагагүй үйл ажиллагааны улмаас ой мод цөөрснөөр хөрсний хамгаалалтын давхарга нимгэрч, ус хадгалах чадвар болон үржил шим нь буурдаг. Үүний улмаас бороо, цасны ус хөрсөнд гүехэн нэвчиж, хөрсний чийг хурдан алдагдана. Улмаар хүчтэй, аадар борооны дараа гол мөрөн үерлэж, эргээд богино хугацаанд хатаж хуурайших үзэгдэл нэмэгдэж байна. Энэ нь үер, ган зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамж жил ирэх тусам нэмэгдэхэд нөлөөлж байна. Иймээс ой модыг хамгаалж, зөв аргаар тарьж арчлах нь чухал юм.

Олон төрөл зүйлийн ургамал, амьтантай ой мод нь нэг төрлийн модтой ойг бодвол өвчин эмгэг, уур амьсгалын өөрчлөлтөд илүү тэсвэртэй байдаг. Нэг төрөл зүйл нь өвчинд нэрвэгдэхэд бусад нь экосистемийг авч үлддэг. Мод тарьж, ойжуулснаар ховордож буй ургамлын үр, генийг хамгаалж, ирээдүй хойч үедээ үлдээх боломж бүрдэнэ. Мод тарих нь зөвхөн агаар цэвэршүүлэх биш, "Амьдралын сүлжээ"-г нөхөн сэргээж байгаа хэрэг юм. Таны тарьсан нэг мод хэдэн зуун төрлийн шавьж, шувуу, бичил биетний амьдрах эх үүсвэр болдог.

АЖЛЫН ХУУДАС-1

Сэдэв 1. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ИРГЭДИЙН ОРОЛЦОО

I. Доорх асуултуудад хариулж бичнэ үү.

1. Уур амьсгалын өөрчлөлт гэж юу вэ? (Таны амьдралд болон хүрээлэн буй орчинд ямар өөрчлөлт мэдрэгдэж байна вэ?)

.....

2. Танай дүүрэг/ хороонд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ямар асуудал хамгийн их мэдрэгдэж байна вэ?

.....

3. Мод тарьснаар эдгээр асуудлыг хэрхэн бууруулах боломжтой гэж та үзэж байна вэ?

.....

II. Та өдөр тутмын амьдралдаа байгальд хэр их нөлөө үзүүлж байгаагаа үнэлээрэй.

Үйлдэл	Тийм	Үгүй	Заримдаа
Би хог хаягдлаа ангилан хаядаг уу?			
Би гэрээсээ гарахдаа гэрлээ унтраадаг уу?			
Би ойрхон газарт алхдаг эсвэл дугуй унадаг уу?			
Би гялгар уутнаас татгалзаж, даавуун уут ашигладаг уу?			

III. Байгаль дэлхийгээ хамгаалахын тулд одооноос хэрэгжүүлж эхлэх 3 алхмаа бичээрэй.

1. Би өнөөдрөөс эхлэн -аас татгалзана.
2. Би гэр бүлийнхээ хүрээнд дадал хэвшүүлнэ.
3. Би уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг төсөл, үйл ажиллагаанд оролцоно.

Мод ба ойн ач холбогдол



2.1 МОД БА ОЙ

Амьтан, ургамал, мод, бут сөөг, цэцэг навч бүхий ургамал, хөвд, мөөг, хөрс, жигүүртэн, шавж зэрэг амьд зүйлс болон ус, шим тэжээл, хад чулуу, нарны гэрэл, агаар гэх мэт амьгүй зүйлсийн нэгдэл болж байгаль орчинд нөлөөлж, бидний амьдрах орчин болдог нийлбэрийг ой гэнэ.

Харин мод нь ойн гол бүрдүүлэгч хэсэг юм. Модны титэм нь нарны шууд тусгалыг хааж, газрын гадаргыг хэт халалтаас хамгаална. Ингэснээр ойн дотор чийглэг, сэрүүн “бичил ертөнц” үүсэж, тэр орчинд нь эмзэг цэцэгс, хөвд, хаг ургах боломж бүрддэг. Модны үндэс нь хөрсийг бэхжүүлж, агааржуулалт хийхээс гадна мөөгөнцрийн сүлжээгээр (микориза) дамжуулан бусад ургамалтай мэдээлэл, шим тэжээл солилцдог. Үүнийг эрдэмтэд “Ойн интернэт” гэж нэрлэдэг.

Модны тухай сонирхолтой фактууд



Модтой орчинд амьдардаг хүмүүсийн стресс багасаж, сэтгэл санаа илүү тогтвортой байдаг.



Эрүүл, тэсвэртэй нэг мод жилдээ их хэмжээний хүчилтөрөгч ялгаруулж, агаар цэвэршүүлдэг. Зарим судалгаанд тухайн мод нь төрөл, хэмжээ, орчноосоо хамаарч 100+ кг хүчилтөрөгч ялгаруулдаг гэж үзсэн байдаг.



Нас бие гүйцсэн нэг мод жилд дунджаар 20–25 кг нүүрстөрөгч шингээдэг.



Мод эргэн тойрондоо ургамал, шавж, амьтдын амьдрах орчныг бий болгодог.



Дэлхийн хамгийн өндөр мод бол АНУ дахь 116 метрийн өндөр бүхий Hyperion гэх мод юм. Энэ мод нь ойролцоогоор 30–40 давхар барилгатай тэнцэнэ. Өндөр мод нарны гэрлийг үр дүнтэй ашиглаж, илүү их хүчилтөрөгч ялгаруулдаг.



Модны үндэс хөрсийг барьж, салхи болон усны элэгдэлд орохоос сэргийлдэг. Энэ нь Монгол орны хувьд цөлжилтийг зогсоох хамгийн гол арга юм.



Зуны халуунд модтой хэсгийн агаарын температур задгай талбайгаас 2-8°C-аар сэрүүн байдаг. Энэ нь навчнаас ус уурших (транспираци) үзэгдэлтэй холбоотой.

2.2 МОНГОЛ ОРНЫ ОЙН САН

Дэлхийн хуурай газрын нийт талбай нь ойролцоогоор 149 сая км² бөгөөд үүний 31% -ийг ой мод эзэлдэг. Хэрэв энэ 31% бүүрсаар байвал хуурай газрын амьтан, ургамлын зүйлийн 80% нь ойд амьдардаг тул тэд орох оронгүй болно. Мөн ой мод нь агаар мандал дахь нүүрстөрөгчийг шингээх хамгийн том хүчин зүйл бөгөөд 1.6 тэрбум хүн амьжиргаагаа шууд ой модтой холбон авч явдаг.

Харин Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн ердөө 7,9-8% нь ой модтой. Өөрөөр хэлбэл, Монгол орны ой нь дэлхийн дунджаас даруй 4 дахин бага бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 92% нь ойгүй.



© themapcreators - БОАЖЯ

Манай орны ойн сангийн нийт талбай 18,3 сая га бөгөөд үүний 12,9 га нь ой модоор бүрхэгдсэн талбайд хамаарна. Ойн талбайн 74%-ийг шилмүүст болон навчит ой, 26%-ийг найлзуурт болон заган ой тус тус эзэлдэг. Монгол орны ойн сан 140 гаруй зүйлийн мод, сөөгөөс бүрддэг бөгөөд ойн сангийн талбайн 83,1% нь хамгаалалтын бүсийн ойд хамаардаг.

Монгол орны ой нь гол мөрний эхийг хамгаалах, усны нөөцийг зохицуулах, хөрсийг тогтоон барих, цөлжилтийг сааруулах чухал үүрэгтэй “ногоон хэрэм” болдог учраас одоо байгаа ойгоо хамгаалах, нөхөн сэргээх, шинээр мод тарих нь байгаль орчны төдийгүй үндэсний аюулгүй байдлын чухал асуудал юм.

2.2.1 Ойн хомсдол, доройтол

- Сүүлийн 20 жилд түймэр, хөнөөлт шавжийн хор хөнөөл, хууль бус мод огтлолт зэргээс шалтгаалан 1,2 сая га ойн талбай хорогдсон.
- Монгол орны ойн нөөцийн 74 хувийг болц гүйцсэн, хөгшин ой эзэлж байна.
- Монгол орны ой мод нь хойд хэсгийн тайга, ойт хээр, уулын бүс болон говийн бүсээр тархан ургасан заган ойгоос бүрддэг. Энэ нь дэлхийн дунджаас (31%) харьцангуй бага хувь бөгөөд Монгол орон говь, хээрийн бүс давамгайлсан орон гэдгийг харуулж байна.

2.2.2 Ойн экосистемийн онцлог

Монгол орны ойн экосистем ерөнхийдөө шилмүүст ойн экосистемд хамаардаг. Монголын шилмүүст ой нь дэлхийн хамгийн өргөн хүрээний тасралтгүй ойтой бүсийн нэг хэсэг бөгөөд Азийн хамгийн сайн хадгалагдсан ойн нэг. Эдгээр ой нь хүйтэн уур амьсгал, мөнх цэвдэг, улирлын хуурайшилтын дор байдаг бөгөөд шинэс, гацуур, жодоо, нарс зэрэг шилмүүст модтой.

Зөвхөн Монголд шинэс давамгайлсан дэд тайгын бүс байдаг. Эдгээр нь Монголын нийт газар нутгийн 6,1% буюу 9,5 сая га талбайг эзэлдэг. Хэт их ашиглалт, дарамтын улмаас энэ шилжилтийн бүсийн ой нь хээр тал болж хувирах тохиолдол бий. Голын сав дагуух болон жижиг хэсэг ой мод нь байгаль орчны тэнцвэр, төрөл зүйлийн хамгаалал, хүний амьдралд чухал ач холбогдолтой.

Монгол орны ой нь голдуу эрс тэс уур амьсгалтай бүсэд тархдаг бөгөөд ийм нөхцөлд модны байгалийн ургалт удаан, нөхөн сэргэх хугацаа урт байдаг. Модны үндэс хөрсөнд усыг барьж, гол горхи, булаг шанд тасралтгүй урсах нөхцөлийг бүрдүүлдэг. Харин ой устаж доройтоход ус хурдан ширгэж, ган гачиг нэмэгдэх эрсдэлтэй.

2022 оны байдлаар Монголын нийт нутаг дэвсгэрийн ойролцоогоор 77% нь цөлжиж, доройтсон бөгөөд 362 гол горхи, нуур, булаг шанд ширгэсэн байна. Хуурайшилт, эрс тэс уур амьсгал нь Монгол орны ойн доройтлыг улам хурцатгаж байна.

Эрс тэс уур амьсгал, хуурайшилтаас гадна хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэн ой хомсдож байна. Тодруулбал, хууль бусаар мод огтлох, түймэр, хотжилт, бэлчээрийн тархалт, хортон шавжийн тархалт зэрэг нь ойд дарамт учруулдаг.

2.3 НАЛАЙХ ДҮҮРГИЙН ГАЗАР ЗҮЙН БҮТЭЦ

Налайх дүүрэг нь Хэнтийн нурууны баруун өмнөд төгсгөл, Туул голын хөндийд байрладаг. Дүүргийн хойд болон зүүн хойд хэсэг нь Хэнтийн нурууны салбар уулс болох Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газартай хиллэдэг. Энд алдарт “Мэлхий хад” зэрэг сонин тогтоцтой хад чулуу, боржин бүхий уулс элбэг. Налайх дүүргийн байгалийн бүтцийн хамгийн чухал хэсэг нь Туул гол юм.

Туул гол дүүргийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөхдөө гүний усны томоохон нөөцийг бүрдүүлдэг. Энэ нь зөвхөн дүүргийн төдийгүй нийслэл хотын ундны усны эх үүсвэрийн чухал хэсэг болдог. Голын дагуух бургасан ой, нуга нь нүүдлийн шувууд болон зэрлэг амьтдын амьдрах таатай орчин болдог.

Дүүргийн төв болон өмнөд хэсэг нь Туул голын сав газар, тэгш тал руу шилждэг. Энэ нь мал аж ахуй болон суурьшлын бүс болоход нөлөөлсөн.

Цаг уурын эрс тэс, хуурай эх газрын уур амьсгалтай. Жилийн турш агаарын температур, цаг агаарын нөхцөл байнга өөрчлөгдөж, улирлын болон хоногийн хэлбэлзэл ихтэй байдаг. Улаанбаатар хотын төв хэсгийг бодвол агаарын температур харьцангуй сэрүүн, салхины урсгал сайтай байдаг нь агаарын бохирдол сарних нөхцөлийг бүрдүүлдэг.

Налайхын байгалийн бүтэц нь геологийн хувьд маш баялаг түүхтэй. Нүүрсний орд баялагтай, боржин, элсэн чихэр, шохойн чулуу зэрэг барилгын материалын түүхий эд болох эрдэс баялаг ихтэй.

Уулын хээрийн бүс учраас бэлчээрийн шимт ургамал, эмийн ургамлууд (алтан хундага, согоон чих г.м) элбэг. Горхи-Тэрэлжтэй хиллэдэг хэсгээр хандгай, буга, бор гөрөөс, зэрлэг гахай зэрэг ой тайгын амьтад нутагшдаг бол тал хээр хэсгээрээ үнэг, хярс, туулай элбэг тохиолддог.

Налайх нь уулын ойн хээрийн бүсэд хамаардаг тул байгалийн бүс бүслүүрийн шилжилтийн шинж чанарыг агуулдаг. Хойд хэсгийн уулсаар шинэс, нарс, хус мод бүхий ойтой. Энэхүү ой нь нийслэлийн агаарыг цэвэршүүлэх, усны нөөцийг барих стратегийн ач холбогдолтой.

Байгалийн бүтцийн хувьд “Хан Хэнтийн дархан цаазат газар” болон “Туул голын сав газар”-ыг холбосон экологийн коридор юм. Тиймээс энд мод тарих, ойн зурвас байгуулах нь бичил уур амьсгалд чухал нөлөөтэй төдийгүй нийслэлийн тоосжилтыг бууруулах, усны нөөцийг хамгаалахад шийдвэрлэх үүрэгтэй.



© <https://www.nad.ub.gov.mn>

Хөрсний онцлог

Налайх орчмын хөрсний бүтэц нь газар зүйн онцлог, өндөрлөгийн бүсчлэл, геокриологийн нөхцөл болон сул чулуулгийн зузаанаас шалтгаалан өөр өөр байдаг. Хэнтийн нурууны салбар уулсын өндөрлөг хэсгээр хүнд саарал, ойн саарал, хужирлаг хөрс болон литозем (чулуурхаг хөрс) хөрс зонхилно. Уулын хээр, бэлчээрийн хөрсөнд органик бодисын хуримтлал бүхий давхарга ажиглагддаг.

Уулын хөрсний үндсэн онцлог нь чулуулаг ихтэй бөгөөд хөрсний доод хэсэгт чулуулгийн хэмжээ нэмэгддэг. Зарим судалгаагаар хөрс нь хөнгөн шаварлаг болох нь тогтоогдсон. Хөрсний үржил шим нь органик бодисын, ялангуяа ялзмагийн агууламжаар тодорхойлогдоно. Дээд давхаргад ялзмаг харьцангуй өндөр байж болно.

Уулын гадаргуугийн өөрчлөлт, уурхайн үйл ажиллагаа, замын бүтээн байгуулалт зэргийн улмаас хөрсний бүтэц, үржил шим доройтсон талбай олон байдаг.

Дүүргийн 1-8 дугаар хорооны газар зүйн онцлог, уур амьсгалын нөлөөг ангилан харууллаа.

№	Хороо	Газар зүйн онцлог	Уур амьсгал
1	Нэгдүгээр хороо	Дүүргийн баруун хойд хэсэгт, Хэнтийн нурууны салбар уулсын бэлд байрладаг. Улаанбаатараас ирэх гол замын дагуу байршилтай.	Уулын ам дагасан салхины урсгал ихтэй. Хөрс нь хайрцаг чулуулаг ихтэй, уулын бэл учраас хавар, намар температур огцом хэлбэлздэг.
2	Хоёрдугаар хороо	Дүүргийн төв хэсэг бөгөөд орон сууцны хорооллууд төвлөрсөн.	Дулаан дамжуулах шугам, барилга байгууламж ихтэй тул “хотын дулаан арлын” нөлөө ажиглагдана. Салхинаас хамгаалагдсан, тогтуун байх нь элбэг.
3	Гуравдугаар хороо	Төмөр замын шугам дагуу, дүүргийн төвөөс зайдуу хэсэгт байрладаг. Харьцангуй тэгш гадаргуутай.	Хот суурин газрын бичил уур амьсгал давамгайлна. Төв замын хөдөлгөөн болон гэр хорооллын утаа, хогийн цэгийн нөлөөнөөс хамаарч өвлийн улиралд агаарын бохирдолд өртөх магадлалтай.
4	Дөрөвдүгээр хороо	Дүүргийн төвөөс зүүн урагш, хуучин нисэх буудлын орчимд байрладаг. Өргөн уудам тэгш тал бүхий газар.	Тал хээрийн шинжтэй. Салхины хурд их, шороон шуурганд өртөмтгий. Зун нь бусад хороодоос харьцангуй халуун, хуурай байдаг.
5	Тавдугаар хороо	Туул голын өмнөд хэсэг, голын хөндийн дагуух бүс. Нам дор газар нутаг.	Чийглэг уур амьсгалтай. Туул голын ууршилтаас хамаарч, манан татах нь элбэг. Өвөл нь нам дор газар тул хүйтэн агаар хуримтлагдаж илүү хүйтэн байдаг.
6	Зургадугаар хороо	Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын нутаг дэвсгэрийг хамардаг. Налайхын хамгийн үзэсгэлэнтэй, уулархаг, ой мод, гол горхи хосолсон бүс.	Уулын бичил уур амьсгалтай. Жилийн хур тунадас дүүргийн бусад хэсгээс илүү, зун нь сэрүүн, өвөл нь уулын хөндийд хүйтэн агаар тогтох үзэгдэл ажиглагддаг.
7	Долдугаар хороо	Дүүргийн төв хэсэгтэй залгаа, хорооны байршил тархай бутархай, нам дор болон өндөрлөг хэсэг хосолсон бүс.	Эрс тэс уур амьсгалтай, тал хээрийн салхи ихтэй. Хөрс нь бэлчээрийн зориулалтаар ашиглахад тохиромжтой ч сүүлийн жилүүдэд хуурайшилт ихсэж байгаа.
8	Наймдугаар хороо	Налайхын нүүрсний уурхайн орчим, уул уурхайн олборлолтын нөлөөнд орсон газар нутаг.	Налайхын нүүрсний уурхайн орчим, уул уурхайн олборлолтын нөлөөнд орсон газар нутаг. Хөрс намгархаг болон цэвдэгтэй тул үерийн эрсдэл өндөр.

2.4 НАЛАЙХЫН НӨХЦӨЛД ТОХИРОМЖТОЙ НОГООН БАЙГУУЛАМЖ

1. Шилмүүст модод (Эрс тэс уур амьсгалд тэсвэртэй)

Модны нэр	Онцлог
Сибирийн нарс	Хүйтэнд маш тэсвэртэй. Аажмаар ургадаг. Эгц налуу, чулуурхаг хөрсөнд тохиромжтой.
Сибирийн гацуур	Хүйтэн, сүүдэрт тэсвэртэй. Хөрсний чийг бага зэрэг шаарддаг. Ойн нөхөн сэргээлтэд чухал.
Сибирийн хуш	Монголын хамгийн түгээмэл мод. Хүйтэнд тэсвэртэй, гэрэлд дуртай. Эдийн засгийн ач холбогдолтой. Уулын нөхцөлд сайн ургана.

2. Навчит модод (Хуурайшилт ба бүх хөрсөнд тэсвэртэй)

Модны Нэр	Онцлог
Хусан мод	Хүйтэнд тэсвэртэй. Хөрсний ямар ч нөхцөлд тэсвэртэй. Хурдан ургадаг. Чимэглэлийн зориулалттай. Эхний ээлжийн ойжуулалтад сайн.
Улиас	Хурдан ургадаг. Салхины хамгаалалт болон ногоон байгууламжид тохиромжтой.
Үхрийн нүд	Хуурайшилт, тоосжилт, хөрсний бохирдолд маш тэсвэртэй. Гэрэлд дуртай. Уурхайн орчны нөхөн сэргээлтэд тохиромжтой.
Бургас	Гол горхи, чийгтэй хэсэгт тарихад нэн тохиромжтой. Хурдан ургаж, хөрсний элэгдлээс хамгаална.

2. Навчит модод (Хуурайшилт ба бүх хөрсөнд тэсвэртэй)

Модны Нэр	Онцлог
Чацаргана	Хөрсний давсжилт болон хуурайшилтад тэсвэртэй. Элсэрхэг, чулуурхаг хөрсөнд ч сайн ургана. Хөрсний азотыг бэхжүүлнэ.
Нохойн хошуу	Хүйтэнд болон хөрсний бохирдолд тэсвэртэй. Хөрс хамгаалдаг. Чимэглэлийн зориулалттай.
Үхрийн нүд	Хуурайшилт, тоосжилт, хөрсний бохирдолд маш тэсвэртэй. Гэрэлд дуртай. Уурхайн орчны нөхөн сэргээлтэд тохиромжтой.
Торниун алим, Давжаа алим	Алимны бүх сорт элсэнцэр, хөнгөн шавранцар, ус нэвтрүүлэх чанар сайтай, шим тэжээлтэй хөрсөнд сайн ургана.

АЖЛЫН ХУУДАС-2

I. Доорх асуултуудад хариулж бичнэ үү.

1. Монгол орны ойн сан дэлхийн дунджаас хэд дахин бага байна вэ?

.....

.....

2. Манай орны ойн санг бүрдүүлдэг гол моддыг нэрлээрэй. (Санамж: Налайхын хойд уулсаар байдаг моднууд)

.....

.....

II. Зөв харгалзуулаарай.

Газарзүйн үзүүлэлт	Онцлог
А. Горхи-Тэрэлж	1. Хөрсний бүтцэд өөрчлөлт орсон, нөхөн сэргээлт шаардлагатай бүс.
Б. Туул голын сав газар	2. Гранит хад, шинэсэн ой бүхий аялал жуулчлалын бүс
В. Нүүрсний сав газар	3. Дүүргийн ундны усны эх үүсвэр, экосистемийн гол судас
Г. Уулын ойн хээр	4. Ой болон тал хээрийн шинж чанарыг зэрэг агуулсан бүс

III. Налайх дүүргийн 1-8-дугаар хороодын хөрс, уур амьсгалд тохируулан ямар мод тарих нь зөв бэ? Сонголтоо хийнэ үү?

Онцлог	Байршил	Сонголт		
		Шинэс	Нарс	Хус
Хойд талын уулархаг хэсэгт	(6,7-р хороо)	Шинэс	Нарс	Хус
Голын ай сав, чийглэг хэсэгт	(1,5-р хороо)	Бургас	Улиас	Ганга
Гэр хороолол, төв зам дагуу	(2,3, 4,8-р хороо)	Хайлаас,	Монос	Шар хуайс

Мод тарих аргачлал



Мод тарина гэдэг нь зөвхөн “нүх ухаад мод суулгах” төдий ажил биш, амьд экосистемийг тэтгэх хөрөнгө оруулалт юм. Мод тарьж, ургуулах нь нэг удаагийн ажил биш, харин байнгын арчилгаа, анхаарал шаарддаг гэдгийг санаарай.

3.1 ХАШААНДАА ТАРИХ МОДОО ХЭРХЭН СОНГОХ ВЭ?

Хашаандаа мод тарихдаа, юуны өмнө зөв байрлал сонгох нь чухал. Тухайн модыг ямар зорилгоор тарьж байгаагаас шалтгаалан хашааныхаа аль хэсэгт тарихаа шийднэ. Налайхын хүйтэн, хуурай салхи ихэвчлэн баруун, хойд зүгээс ирдэг тул энэ чиглэлд өндөр, нягт мод тарих нь хашааны болон гэрийн дулаанаа алдахаас хамгаална. Налайх дүүргийн 7 дугаар хороо хуурайшилт ихтэй, салхитай бүсэд байрлалтай тул үүнийг харгалзан хайлаас, улиас, бургас, шар хуайс зэрэг модыг салхины дээд хэсэгт тарих хэрэгтэй.

Хашаандаа жимсний мод тарихдаа нар сайн тусдаг, салхинаас халхлагдсан, дулаан хэсэгт тарих хэрэгтэй. Харин явган хүний зам, хашааны дотор талын гол шугам дагуу гүйлс, буйлс зэрэг модыг тарих нь тохиромжтой бөгөөд харагдах байдал болон сүүдэр үүсгэх байдлыг харгалзан тайралт, хэлбэржүүлэлт хийх хэрэгтэй.

Хашааны гадна тал эсвэл хашлага шаардлагатай хэсэгт нягт, бат бөх, хөрсийг бэхжүүлдэг мод тариарай. Харин муу усны нүх, жорлонгийн ойролцоо анхилуун үнэртэй монос, голт бор зэрэг мод таривал муу усны үнэрийг дарах ач холбогдолтой.

Налайх дүүргийн газар зүйн онцлогийг харгалзаж хөрсөө ялзмаг, бууцтай хольж сайжруулж тарих нь эхний ургалтад чухал. Тариалалт хийсний дараах 2-3 жилд тогтмол, хангалттай услах нь модыг үндэслэхэд чухал нөлөөтэй. Хамгаалалтын болон гоо зүйн үүрэгтэй модонд жил бүр тогтмол тайралт хийж, хэлбэржүүлэн, эрүүл байлгах нь чухал.

Амьдарч буй орчиндоо мод тарьснаар эрүүл, ногоон орчныг бүрдүүлэхээс гадна уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авч буй бодит алхам болно.



3.2 МОД ТАРИХ АРГАЧЛАЛ

1. Хөрс бэлтгэх

Мод тарих газрыг урьдчилан бэлтгэхдээ тухайн орон нутгийн цаг агаарын онцлог, хөрсний бүтэц зэргийг анхаарах нь зүйтэй. Хөрс нь элс, шороо, ус, агаар, шим тэжээлийн бордоог нэгэн зэрэг агуулсан бүтэцтэй байна.

- Хүрэээр зөөлөн гишгээд тавьсан шороо бутарч байвал хөнгөн хөрс,
- Хөрснөөс атгаж аваад гар дээрээ бөөрөнхийлж үзэхэд барьцалдан бутрахгүй зунгааралдаж, наалдамхай шигүү бүтэцтэй, ус чийг нэвтрүүлэхдээ тааруу бол шаварлаг хөрс,
- Барьцалдахгүй, маш сул бутарч байвал элсэрхэг хөрс тул дулааны улиралд байнга услах шаардлагатай. Иймд хөрсийг сайжруулахын тулд шим тэжээлээр хангаж өгнө.

2. Бордоо бэлтгэх

Модны үндэс ургалтыг сайжруулахын тулд бордоо бэлтгэнэ. Бордоог бэлтгэхдээ, гүйцэд ялзарсан хөх бууц, тахиа шувууны сангас, модны үртэс, том ширхэгтэй элс, био ялмаг болон гумины бордоо ашиглана.

3. Тариалалтын өмнөх бэлтгэл

Мод, бут тарихын өмнө үндсийг гумины уусмалд ойролцоогоор 1/3 хэмжээтэй дүрж хонуулаад тарина.

Модыг тарьсны дараа 7-10 хоногийн зайтай 2-3 удаа үндсийг бордоно. Бордохдоо гуматын уусмал ашиглана. 20 литр усанд 15-20 грамм буюу 4-6 цайны халбага уусмал хийнэ. Энэ арга нь модыг шинэ орчинд хялбар дасгах, өвлийн хүйтнийг тэсвэрлэх чадварыг нь нэмэгдүүлнэ.

4. Био ялмагийн ач холбогдол

Био ялмаг нь бууц, ургамлын үлдэгдэл хогийг чийгийн улаан хорхойгоор боловсруулж гаргасан экологийн цэвэр бүтээгдэхүүн юм. Био ялмаг нь:

- Жимсний мод, бутны хөрсний үржил шимийг дээшлүүлнэ.
- Ургацыг түргэсгэж, жимсний болцод эерэгээр нөлөөлнө.

5. Хөрсний ач холбогдол

Хөрс нь байгалийн экосистемийн тэнцвэрийг хадгалж байдаг (1 см зузаан хөрс үүсэхэд 100-аас 1,000 жил зарцуулагддаг) чухал нөөц юм. Тиймээс мод суулгахаас илүүтэй хөрсийг хамгаалах нь хамгийн чухал.

Хөнгөн, сэвсгэр бүтэцтэй хөрс нь өнгөн хэсэгтээ төдийгүй гүн давхаргад ч чийг сайн хадгалах, ус, бордоог сайн шингээх, үндэсний амьдрах чадварыг эрс нэмэгдүүлдэг давуу талтай. Энэ нь мод, бутны ургалт болон тэсвэрлэх чадварыг сайжруулдаг.

3.3 МОД ТАРИХАД ТОХИРОМЖТОЙ ҮЕ

Мод тарих хугацаа

Мод тарих хугацаа нь газар зүйн байршил, цаг уурын онцлог болон модны төрлөөс шалтгаалж өөр өөр байдаг. Манай орны нөхцөлд хавар, намрын улиралд мод тарих нь тохиромжтой.

№	Тариалах хугацаа	Анхаарах зүйл
1.	Намар 9 дүгээр сарын 25-наас 11 дүгээр сарын 01-ний хооронд буюу газар хөлдөхөөс өмнө тариалалтыг хийнэ.	Эрт хүйтрэх магадлалтай бол 10 дугаар сарыг хэт хойшлуулахгүй байх хэрэгтэй. Хүйтрэхээс өмнө үндэслэж амжихгүй бол өвөлдөө хөлдөж гэмтэх эрсдэлтэй.
2.	Хавар 4 дүгээр сарын 25-наас 6 дугаар сарын 01-ний хооронд буюу газар гэссэний дараа, нахиа задраагүй байх үед хаврын тариалалтыг хийнэ.	Хөрсний температур +5°C-аас дээш дулаарсан байх нь чухал. Оройн болон шөнийн хүйтэн жавар буураагүй бол хүлээх хэрэгтэй.

Хавар/Намар ямар мод тарих вэ?

№	Модны төрөл	Тарих хугацаа	Зөвлөмж
1	Навчит мод (Хус, улиас, бургас, үхрийн нүд)	Хавар (4 дүгээр сарын сүүлээс 5 дугаар сар)	Намар ч боломжтой. Гэхдээ хавар тарихыг илүүд үздэг. Навч нь унасан байх үед шилжүүлэн суулгах нь тохиромжтой.
2	Шилмүүст мод (Нарс, гацуур, хуш)	Хавар (4 дүгээр сарын сүүлээс 5 дугаар сар) Намар (9 дүгээр сар)	Шилмүүст модны суулгацыг хөрсөндөө сайн дасгаж, нүүдлийн явцад үндэсний хөрсийг нь (савтайгаар) гэмтээхгүй байх нь чухал.
3	Бортого/Савтай суулгац	Улирал харгалзахгүй (4 дүгээр сараас 9 дүгээр сар)	Савтай суулгацыг хөрс хөлдөөгүй үед (бүр зуны халуунд ч гэсэн) тарьж болдог. Гэхдээ хамгийн тохиромжтой үе нь хавар, намар юм.

3.4 МОД ТАРИХ ДАРААЛАЛ

Үе шат	Хийгдэх ажил	Зөвлөмж
Бэлтгэл	Суулгацаа сонгож, газар бэлтгэх	Тухайн бүс нутгийн уур амьсгалд тохирох, гэмтэлгүй, эрүүл, үндэс нь сайн хөгжсөн суулгацыг сонгоно.
		Нарны гэрэл, ус зайлуулах нөхцөл, хөрсний бүтэц зэргийг үнэлж, тариалах байршлыг сонгоно.
Нүх ухах	Нүхний хэмжээг тодорхойлох	Нүхийг суулгацын үндэсний хэмжээнээс 2-3 дахин өргөн, харин гүн нь үндэсний өндөртэй тэнцүү байхаар ухна. Нүхийг гүн ухвал суулгацыг хөрсөнд хэт гүн суулгахад хүргэж болзошгүй.
	Хөрс	Ухсан нүхний дээд талын үржил шимтэй хөрсийг доод талынхтай нь холихгүйгээр тусад нь тавина.
Суулгац Бэлтгэх	Үндэсний гэмтлийг засах	Хэрэв үндэс хэт урт, эсвэл гэмтэлтэй бол үзүүрийг нь хурц хайчаар зөөлөн тайрч цэвэрлэнэ.
	Савнаас гаргах	Хэрэв савтай бол үндэсний бөмбөлгийг гэмтээхгүйгээр болгоомжтой гаргаж, үндэс нь хэт орооцолдсон бол зөөлөн задална.
Суулгах	Хөрсөнд байрлуулах	Суулгацыг нүхэнд хийхдээ үндэсний хүзүү (үндэс ба ишний зааг) нь газрын гадаргатай тэнцүү эсвэл түүнээс бага зэрэг дээш байхаар байрлуулна.
	Нүхийг дүүргэх	Ухсан нүхний үржил шимтэй хөрсийг (шаардлагатай бол ялзмаг, бордоогоор сайжруулсан) ашиглан нүхийг дүүргэнэ. Хөрсийг нягтруулахдаа хөлөөр бус, гарын алгаар зөөлөн дарж нягтруулна.
Услах ба бэхлэх	Эхний усалгаа	Модыг суулгасны дараа хангалттай хэмжээний (5-10 литр) усаар усална. Энэ нь хөрсний завсрыг дүүргэж, үндэс орчмын агаарыг гадагшлуулдаг.
	Бэхлэх	Хэрэв суулгац өндөр, салхинд хийсэх магадлалтай бол нэг эсвэл хоёр тулгуур мод ашиглан зөөлөн уяагаар бэхэлнэ. Тусгаарлагчийг нэг жилээс илүү хугацаагаар байлгахгүй байх нь чухал.
Арчилгаа	Хөрсний хучилт	Модны үндэс орчмын хөрсийг 5-10 см зузаантай органик (үртэс, сүрэл, хуурай навч) эсвэл чулуугаар хучиж өгнө. Энэ нь чийгийг хадгалж, хог ургамлын өсөлтийг зогсооно. Эхний 1-3 жилд чийгшлийг сайтар хянаж, зөв арчилж чадвал ургах үйл явц байгалиараа үргэлжилнэ.

3.5 МОД ТАРИХАД АНХААРАХ ЗҮЙЛС

Мод тарих нь байгаль эхэд оруулж буй хамгийн том хөрөнгө оруулалт боловч тарьсан модоо амжилттай ургах нөхцөлийг бүрдүүлэх нь хамгийн чухал юм. Мод тарихад анхаарах үндсэн зөвлөмжүүдийг дараах дарааллаар хүргэж байна.

1. Мод тарих хугацааг зөв сонгох

Монгол орны нөхцөлд модыг хавар, намрын улиралд тарихад хамгийн тохиромжтой.

2. Суулгацаа зөв сонгох

Модны ургалтад нарны гэрэл, усан хангамж болон хөрсний бүтэц ихээхэн нөлөөтэй. Тиймээс та суулгац сонгохдоо:

- Өөрийн орон нутгийн нөхцөлд ургах чадвартай,
- Мод үржүүлгийн газарт үрээр ургуулсан,
- 3+ настай, 30см+ өндөртэй суулгацыг сонгоорой.



© тэрбум мод үндэсний хөдөлгөөн

3. Нүхээ бэлтгэх (Хамгийн чухал хэсэг)

Модны нүх нь суулгацын үндэснээс 2-3 дахин өргөн байх шаардлагатай. Гүн нь 60-80 см, өргөн нь 70-80 см байна.

Нүх ухахдаа өнгөн хэсгийн хар шороог тусад нь, доод талын хайргатай хөрсийг тусад нь овоолно. Дараа нь хар шороогоо хамгийн түрүүнд үндэсний ёроолд хийнэ.

6. Хамгаалалт

Үндэс орчимдоо шороо багатай модыг үндсийг нь хатахаас өмнө аль болох хурдан хугацаанд суулгах шаардлагатай.

- Хол замд тээвэрлэх бол бортоготой суулгацыг сонгох нь аюулгүй.
- Хаврын улиралд үндэс агаарт ил байвал хурдан хатаж, амьдрах чадвараа алддаг.
- Үндсийг чийгтэй шороо, шавар зуурмаг, зориулалтын уутанд хийж, шаардлагатай тохиолдолд суулгацын үндсийг уусмалд дүрж, чийгтэй орчинд хамгаалах хэрэгтэй.

7. Суулгах

Модны үндэс эхэлж буй хэсгийг (үндэсний хүзүү) газрын гадаргатай ижил түвшинд байлгах хэрэгтэй. Хэт гүн суулгавал үндэс амьсгалж чадахгүй өмхөрнө, хэт гүехэн суулгавал үндэс хатна.

Шороо хийх явцдаа үндэсний завсар агаар үлдэхгүй байхаар хөнгөн гишгэж нягтаршуулна.

8. Анхны усалгаа

Модыг суулгасан даруйд усална. Энэ усалгаа нь зөвхөн чийг өгөх биш, хөрс болон үндсийг хооронд нь нягтаршуулах зорилготой. Усалгааны дараа модны тойргийг өвс, холтос эсвэл бууцаар хучих нь чийгийг удаан хадгалахад тусална.

9. Арчилгаа

Эхний жилдээ долоо хоногт 1-2 удаа (цаг агаараас хамаарч) тогтмол услах хэрэгтэй. Налайх шиг бэлчээрийн мал ихтэй газар заавал хашаа, хамгаалалт хийх шаардлагатай.

Модыг хэт ойрхон тарих нь гэрэл, шим тэжээлийн төлөөх өрсөлдөөн үүсгэж, ургалт мууддаг. Тухайлбал: Гацуур, шинэс, нарс зэрэг модыг хашаа байшингаас 5 метрээс дотогш тарихгүй. Харин чацаргана, монос зэрэг сөөгийг 3 метрээс дотогш тарихгүй байх шаардлагатай.

Мод тарихад анхаарах зай, хэмжээс:



АЖЛЫН ХУУДАС-3

I. Дараах мэдээллийг уншаад Тийм/Үгүй сонголтоо хийнэ үү.

Тайлбар	Тийм	Үгүй
Суулгацыг нүхний голд байрлуулж, үндэсний хүзүүг газрын түвшинтэй ижил байлгана.		
Нүхийг бэлтгэхдээ үндэснээс 2 дахин том (60x60x60 см-ээс багагүй) нүх ухна.		
Хар шороо болон бордооны холимогоор дүүргэж, агаар үлдэхгүйгээр нягтаршуулна.		
Модыг суулгасны дараа шууд 20-30 литр усаар усална. Цаашид усалгааг өглөө эрт эсвэл орой нар жаргасны дараа хийх нь хамгийн үр дүнтэй байдаг.		
Чийгийг хадгалахын тулд модны тойргийг өвс, холтос эсвэл бууцаар хучна.		
Модны үндэсний хүзүүг (үндэс ба ишний зааг) хэт гүн булж болохгүй. Хэт гүн булвал мод “амьсгалж” чадахгүй үхэх аюултай.		

II. Мод тарьсны дараах арчилгааны аргуудыг тайлбарлаж бичнэ үү.

Асуулт 1. Мод тарьсны дараах эхний нэг жилд ямар арчилгаа хамгийн чухал вэ?

.....

.....

Асуулт 2. Усалгааны дараа хөрсийг яагаад сийрэгжүүлэх ёстой вэ?

.....

.....

Асуулт 3. Малын хөл болон салхинаас модыг хэрхэн хамгаалах вэ?

.....

.....

III. Та өөрийн тарих модоо сонгож, түүнийг хэрхэн хайрлах амлалтаа бичээрэй.

- Миний сонгосон модны төрөл:

(Жишээ нь: Хайлаас, Нарс, Шинэс)

- Тарих байршил:

(Жишээ нь: Налайх дүүргийн ...-р хороо, өөрийн хашаандаа)

- Би модоо хэрхэн арчлах вэ? (Би сар бүр хийх болно.)

**Өрхийн
нөхцөлд
тарихад
тохиромжтой
модод**



4.1 ҮР ШИМЭЭ ХУРДАН ӨГӨХ ЖИМСНИЙ МОД

ТОРНИУН АЛИМ

Хөрс: Алимны бүх сортууд элсэнцэр, хөнгөн шавранцар, ус нэвтрүүлэх чадвар сайтай, шим тэжээлтэй хөрсөнд сайн ургана.

Тариалалт хийхэд тохиромжтой хугацаа:

Намар- 9 дүгээр сарын сүүлчээс 10 дугаар сарын эхний хагаст (навч унах үе)

Хавар- 5 дугаар сарын эхний хагаст

Нүх бэлтгэх

Ёроолоороо 100 см, амаараа 120 см голч, 70-80 см гүн нүх ухаж бэлтгэнэ. Нүхийг ухахдаа дээд үржил шимтэй хөрсийг нэг талд, доош ухахад гарсан үржил шим багатай, элс хайргатай үеийг нөгөө талд овоолно.

Бордоо хийх

Дунджаар 8-10 кг бүрэн ялзарсан бууц, 80-100 гр азот, фосфорын бордоог хөрстэй хольж сайтар хутгана.



Суулгах арга

- Үндсийг жигд тараан, налуу хэвтээ байдлаар суулгана.
- Үндэсний хүзүү газрын гадаргатай нэг төвшинд байх ёстой. Хэрвээ үндэсний хүзүү шороонд далд ортол гүн суулгавал иш нь ялзрах эрсдэлтэй. Харин хэт дээр суувал үндэс хатаж гэмтэнэ.
- Залуу алимны модны титэм салаа мөчрүүд нь голдуу үндэснийхээ хэмжээнээс их байдаг. Үндэсний хорогдлыг нөхөх зорилгоор мөчрийг суулгахын өмнө хэвтээ байдлаар хэлбэржүүлнэ.

Мөчрийг тайрах

Суулгацын гол ишийг хажуугийн мөчрүүдээс 20-30 см өндөр байхаар тайрч, гадна талын нахианы дээд талаар налуу өнцгөөр огтолно.

Усжуулалт

Модыг тарьсны дараа эргэн тойронд нь 1-1,5м голчтой тогоо гаргаж сайтар усална.

Өвлийн арчилгаа

- Алимны модыг хэвтээ хэлбэрт оруулж, өвөл хучихын тулд зэгс, сүрэл, бургас, үртэс, шороогоор 10-15 см хучна.
- Хавар (5 дугаар сарын эхээр) хучлагаас гаргана.

Хаврын арчилгаа

Модны ишийг цэвэрлэж, цуурсан ан цавд шохойдно. Энэ нь хортон шавжаас гадна наранд түлэгдэхээс хамгаална.

ДАВЖАА АЛИМ

Давжаа алим нь сортын үндэс дээр суулгац хийж гаргаж авсан жижигхэн мод учраас арчилгаа, хамгаалалт хийхэд хялбар бөгөөд үр жимсээ эрт өгдөг давуу талтай.

Хөрс:

- Налайхын чулуурхаг хөрсийг сайжруулах хэрэгтэй.
- Тариалалтад зориулсан нүхийг том (50x50x50 см) ухах хэрэгтэй.
- Нүхэн дотор ялзмаг (хөрсний үржил шим), малын бууц, элс хольж бэлтгэнэ.
- Хөрсний хүчиллэг чанар (рН) нь 6,0-7,0 байвал тохиромжтой.



Тариалалт хийх тохиромжтой хугацаа:

Хавар: 4 дүгээр сарын сүүлээс 5 дугаар сарын эхэн үе буюу хөрс гэссэний дараа тариалах.

Намар: 9 дүгээр сарын дундуур, хүйтрэхээс өмнө тариалах.

Суулгах арга

- Давжаа алимыг торниун алимтай адил аргаар ургуулна.
- Хүйтэнд тэсвэрлэх чадвар сайтай тул ердийн босоо байдлаар, ил задгай (хучлагагүй) ургуулна.
- Модыг гадсанд бэхлэх шаардлагатай.
- Үндэсний дэвсгэр (үндэсний хүзүүвч) нь газраас дээш байх ёстой. Хэрэв үндэсний дэвсгэр нь шороонд дарагдвал давжаа шинж чанараа алдаж, өндөр ургах эрсдэлтэй.

Арчилгаа, хамгаалалт

Хавар, намрын тариалалтад өвчин, хортон шавж, нар, салхинаас хамгаалж ишийг шохойдож будах

Уусмал бэлтгэх

10 л усанд 2,5-3 кг шохой, 300 грамм зэсийн байван, 1 кг наанги шавар хийнэ. Орчин үед барилгын замаск ашиглаж болдог боловч ийм уусмал модны гадаргууд үүрлэсэн хортон шавжийн үр авгалдайг үхүүлж устгах үйлчилгээтэй байдаг.

ХӨХ ДАЛАН ХАЛЬС

Хөх далан хальс нь Монгол орны нөхцөлд, тэр дундаа Налайх дүүргийн эрс тэс уур амьсгалд тариалахад маш тохиромжтой, үнэ цэнтэй жимсний бут юм. Сүүлийн жилүүдэд Монголын Ургамал, газар тариалангийн хүрээлэн зэрэг байгууллагууд хүйтэнд тэсвэртэй Канад, Оросын сортуудыг амжилттай нутагшуулж байна. -3°C хүртэл температурт цэцэглэх бөгөөд өвөл -40°C хүртэл (Жишээ нь: “Berry Blue” сорт) хүйтнийг тэсвэрлэх чадвартай.



Зургадугаар сарын дунд үед (сортоос хамаарч эхний 20 хоногт) боловсордог. Монголын богино зунтай нөхцөлд маш том давуу тал юм. Олон төрлийн аминдэм, эрдэс (Кальци, Магни, Төмөр) ихтэй. Эмчилгээний болон дархлаа дэмжих өндөр ач холбогдолтой. Нэг бутнаас 3-5 кг жимс авах боломжтой (5-6 настайгаасаа арвин ургац өгч эхэлдэг).

Нүх бэлтгэх

Тариалах нүхийг 50 см диаметртэй, 60 см гүн ухна. Жимс боловсрох үед чийгээр сайн хангах хэрэгтэй. Ургамал хоорондын зай: 1,5–2,0 метр, Эгнээ хоорондын зай нь 3–4 метр байна.

Арчилгаа, хамгаалалт:

Хавар, зундаа 2-3 удаа нэмэлт бордоог (үндсэнд эсвэл шүршиж) өгнө. Бутны хэлбэрийг хадгалах, хуучин болон өвчтэй мөчрүүдийг тогтмол тайрч сийрэгжүүлэх нь ургацыг нэмэгдүүлэхэд тустай.

НОХОЙН ХОШУУ

Нохойн хошуу нь Монгол орны эрс тэс уур амьсгал, ялангуяа Налайх дүүргийн нөхцөлд маш сайн ургах чадвартай, олон талын ач холбогдолтой бут сөөг юм. Маш өндөр тэсвэртэй. Монголын хүйтэн өвлийг асуудалгүй давдаг, гайхалтай тэсвэртэй, ус бага шаарддаг онцлогтой. Ямар ч хөрсөнд ургах бөгөөд хөрсний элэгдэл, эвдрэлээс хамгаалах чадвар сайтай.

Хавар, зуны улиралд цэцэглэнэ. Намар, өвөлд улаан жимсээрээ чимдэг. Жимс нь С витаминаар баялаг, эрүүл мэндэд тустай. Нохойн хошуу нь гэрэлд дуртай.



Нар сайн тусдаг, задгай газар тарихад жимсний гарц, чанар сайжирна. Сүүдэрт ургах боломжтой боловч цэцэглэлт, жимслэх нь бага. Салхины хамгаалалт, амьд хашлага болгох эсвэл хөрсний эвдрэлтэй налуу газарт тарихад тохиромжтой.

Хөрс, бордоо

- Нохойн хошуу ямар ч хөрсөнд ургах боломжтой ч тарих нүхэндээ органик бордоо (ялзмаг, үхрийн баас) нэмж өгөх нь эхний ургалтыг түргэсгэнэ.
- Үндэсний хүзүүвчийг газрын түвшнээс бага зэрэг дор буюу 2-3 см-т байрлуулж тарих нь үндэсний дэвсгэр гаргаж ирэхэд тустай.

Амьд хашаа болгох зорилготой бол суулгац хоорондын зайг 1,0–1,5 метр байлгах нь тохиромжтой.

ҮХРИЙН НҮД

Үхрийн нүд нь Налайх дүүргийн нөхцөлд амжилттай ургах боломжтой, эрс тэс уур амьсгалд тохиромжтой, олон талын ач холбогдолтой бүт юм. Мөн хот болон ойн зурвас байгуулахад хамгийн тохиромжтой. Салхины хамгаалалт (хашаа, зурвас), тоосжилтоос хамгаалах, хотын ногоон байгууламж болон уурхайн нөхөн сэргээлтэд өргөн ашиглагддаг. -40°C хүртэл хүйтэн, ган, хөрсний бохирдол, давсжилтад өндөр тэсвэртэй. Ургалт хурдан. Эхний 3-5 жилд маш хурдацтай өсдөг.

Нүхний диаметр нь 50-60 см, гүн нь 35-40 см байх бөгөөд мод хооронд 2 метрийн зайтай тарина. Нэг бутанд 5-8 кг бууц хийж, ухсан нүхний 1/3-д хөрсний холимогийг хийнэ. Суулгацын үндэсний хүзүүнээс дээш 10 см орчимд хөрсийг хийж суулгана.



Усалгаа, арчилгаа

Эхний 14 хоногт 4 удаа усална. Дараа нь 7 хоногт нэг удаа, зуны улиралд 3-4 удаа, 30-40 л усаар нэвчтэл усална. 3-4 нахиа үлдээж тайрна. 8 дугаар сарын 16-наас 9 дүгээр сарын 15 хүртэл 10-15 хоногт нэг удаа усалж, газар хөлдөхөөс 2-3 долоо хоногийн өмнө цэнэг усалгааг хийнэ. Хөрсийг сийрэгжүүлж, хог ургамлыг түүж устгах ажлыг модны ургалтын хугацаанд 5-6 удаа хийнэ. Ойролцоогоор хоёр долоо хоногт нэг удаа арчилгааг хийх нь зүйтэй.

ЧАЦАРГАНА

Чацаргана нь Налайх дүүргийн нөхцөлд тариалахад тохиромжтой, Монгол орны эрс тэс уур амьсгалд дасан зохицсон, ашиг шим ихтэй жимсний нэг юм. Чацаргана нь -40°C хүртэлх хүйтнийг тэсвэрлэх чадвартай тул өвлийн улиралд асуудалгүй ургах давуу талтай. Ган болон хуурайшилтад тэсвэртэй. Хөрсний үржил шимд шаардлага бага тавьдаг бөгөөд элсэрхэг, чулуурхаг, давсжилттай хөрсөнд ч ургадаг. Чацарганы үндсэн дээр азот бэхжүүлэгч нянгууд амьдардаг тул тухайн хөрсөнд азотын нөөцийг нэмэгдүүлж, бусад ургамлын ургалтад эерэгээр нөлөөлдөг.

Чацарганыг тариалахдаа анхаарах зүйлс:

Чацаргана нь хоёр гэрт ургамал юм:

- Эм (их) мод: Жимс авах гол мод
- Эр (бага) мод: 5-8 эм модод тутамд нэг эр мод заавал тарих хэрэгтэй.
- Эр модыг эм модны ойролцоо, салхины чиглэлийг бодолцон байрлуулна.
- Эм модыг хооронд нь 2-3 метр, эр модыг эм модноос 1,5-2 метрийн зайд тарих нь тохиромжтой.
- 50x50x50 см хэмжээтэй нүхэнд суулгана. Нүхэнд органик бордоо (ялзмаг) болон элс хольж өгвөл эхний ургалтад сайн нөлөөтэй. Үндэсний хүзүүвч нь газраас 2-3 см гүнд байхаар суулгана.
- Чацаргана нь нарны гэрэлд дуртай тул задгай, сүүдэр багатай газарт тарих хэрэгтэй. Сүүдэрт тариалбал жимслэх нь эрс багасна.



4.2 ХУРДАН УРГАЛТТАЙ ЧИМЭГЛЭЛИЙН МОДОД

ГОЛТ БОР

Голт бор нь хөх ягаан болон цагаан өнгийн багц цэцэгтэй анхилуун сайхан үнэртэй бут юм. Ургалт нь 5 дугаар сарын дундаас 10 дугаар сарын эхнийг хүртэл үргэлжилнэ. 4 наснаасаа эхлэн цэцэглэдэг. Зургадугаар сараас долдугаар сар хүртэл цэцэглэлт үргэлжилж, есдүгээр сард үр нь боловсорч, 10 дугаар сард навч нь унаж ургалт гүйцнэ. Зууван дугуй хэлбэртэй зузаан хар ногоон өнгийн навчтай, шулуун бат бөх иштэй. Гоёл чимэглэлийн зориулалтаар дангаар нь болон бусад зүйлийн мод, буттай хослуулан ургуулахад тохиромжтой. Таналт, хяргалт сайн даана. Хэлбэржүүлэхэд нэн үзэмжтэй.

Голт бор буюу “Лайла” гэж нэрлэдэг энэхүү бут сөөг нь Налайх дүүргийн эрс тэс уур амьсгалтай нөхцөлд маш сайн ургах, нутагших боломжтой юм. Голт бор нь хүйтэнд тэсвэртэй, үзэсгэлэнтэй цэцэгтэй, таатай үнэртэй тул Монголын ногоон байгууламжид түгээмэл ашиглагддаг. Хөрсний чанарт өндөр шаардлага тавихгүй ч, сайн агааржилттай, ус тогтохгүй (ус зайлуулах чадвар сайн) хөрсөнд илүү хурдан ургадаг. Налайхын чулуурхаг, элсэрхэг хөрсөнд ч ургана. Тогтсон бут болсны дараа ганд нэлээд тэсвэртэй болдог. Сайн цэцэглэхийн тулд өдөрт дор хаяж 6 цагийн нарны шууд гэрэл шаарддаг. Сүүдэрт таривал цэцэг бага гаргадаг. Салхинд тэсвэртэй. Гэхдээ хүчтэй салхитай газарт эхний жилүүдэд хамгаалалт хийж болно. Голт бор нь саармаг эсвэл сул шүлтлэг (рН 6,5–7) хөрсөнд хамгийн сайн ургадаг. Хөрсний рН-ийг мэдэхгүй бол тарих нүхэндээ ялзмаг болон модны үнс (шүлтлэг чанарыг нэмэгдүүлдэг) нэмж өгөх нь тохиромжтой. Нүхний хэмжээг үндэснээс 2 дахин том ухах, үндэсний хүзүүвч нь газрын түвшинтэй тэнцүү байхаар тарих хэрэгтэй. Хэт гүнд таривал цэцэглэлт муудна. Бут хооронд 2,5–3,5 метрийн зайтай таривал тохиромжтой ба голт бор бүрэн хэлбэрээ олж, агаар сайн нэвтэрч, өвчлөл багасна.



ШАР ХУАЙС

Шар хуайс буюу харгана нь Налайх дүүргийн эрс тэс, хуурай уур амьсгалд тариалахад тохиромжтой, байгаль хамгааллын өндөр ач холбогдолтой олон наст бут сөөг юм. Шар хуайс нь манай орны хүйтэн, хуурай нөхцөлд хамгийн тэсвэртэй. 4–7 метр өндөртэй бут эсвэл жижиг мод хэлбэрээр ургах бөгөөд харьцангуй хурдан ургалттай. Тод ногооноос хар ногоон өнгөтэй олон жижиг навчтай.

5-6 дугаар сард цэцэглэх ба цэцэг нь шар өнгөтэй, анхилуун үнэртэй байдаг. Үр нь буурцаг ба хонхорцогт олноороо байрлана. Үр жимс нь долдугаар сард боловсордог. Тайралт, хяргалтыг сайн даадаг тул амьд хашлага, салхины хамгаалалтын зурвас байгуулахад өргөн ашигладаг.

Шар хуайс нь ган, хуурайшилтад маш сайн тэсвэртэй, ус бага шаарддаг. Хөрсний үржил шим, бүтцэд өндөр шаардлага тавьдаггүй бөгөөд элсэрхэг, чулуурхаг, давсжилттай бүх төрлийн хөрсөнд ургах чадвартай. Үндэсний систем нь сайн хөгжсөн, гүн байдаг тул хөрсний элэгдэл, нуралт, элсний нүүдлээс хамгаалах, налуу болон эвдэрсэн газрыг бэхжүүлэхэд нэн тохиромжтой.

Мөн үндэс дээрээ азот бэхжүүлэгч нян агуулдаг тул хөрсний азотын нөөцийг нэмэгдүүлж, хөрсийг сайжруулах ач холбогдолтой. Үүнээс гадна бал, тоосны өндөр өгөлттэй ургамал бөгөөд байгалийн төгөлд нэг га-аас 350 кг хүртэл бал авах боломжтой гэж үздэг.

Гэрэлд дуртай, нар сайн тусдаг газарт ургалт илүү хурдан. Налайхын нөхцөлд хүчтэй салхины хамгаалалт, элс, тоосжилтоос хамгаалах зурвас, мөн уурхайн нөхөн сэргээлтийн бүсэд ашиглахад тохиромжтой.

Тариалалтыг хавар (4-р сар) эсвэл намрын эхэн (9-р сар)-д хийж болно. Хэдийгээр ямар ч хөрсөнд ургадаг ч тарих нүхэндээ бага зэрэг ялзмаг нэмж өгөх нь эхний ургалтад дэмжлэг үзүүлнэ. Амьд хашлага, салхины хамгаалалтын зориулалтаар тариалах үед суулгац хоорондын зайг 0,5–1 метр байлгавал өтгөн зурвас болж ургана. Эхний жилд үндэслэх хүртэл тогтмол усалгаа шаардлагатай бөгөөд нас бие гүйцсэн үедээ нэмэлт усалгаа бараг шаарддаггүй.



ХАЙЛААС

Хайлаас нь Налайх дүүргийн нөхцөлд амьд хашлага болон ногоон байгууламж байгуулахад нэн тохиромжтой мод юм. Төв Азийн уугуул мод гэгддэг хайлаас нь Монгол, Сибирийн эрс тэс уур амьсгалд бүрэн дасан зохицсон, ган, хуурайшилтад тэсвэртэй.

Тайраагүй тохиолдолд 10-15 метр хүртэл өндөр ургах боломжтой боловч ихэвчлэн тайрч, бут хэлбэртэй эсвэл намхан амьд хашлага болгон ургуулдаг. Ургалт маш хурдан тул богино хугацаанд ногоон байгууламж бий болгох боломжтой. Навч нь жижигхэн, гонзгой хэлбэртэй, хар ногоон өнгөтэй бөгөөд намар шаргал өнгөтэй болдог.

Үндэс нь гүн, өргөн тархсан тул хөрсийг сайн бэхжүүлдэг бөгөөд салхинд хугарах эрсдэл бага. Энэ нь хайлаасыг салхины хамгаалалтын зурвас болж хөрсний элэгдлээс хамгаалах, тариалангийн талбайг салхинаас хамгаалах зорилгоор ашиглахад тохиромжтой болгодог. Мөн хотын агаарын бохирдол, тоосжилт, хөрсний механик гэмтэлд тэсвэртэй тул гудамж талбай, үйлдвэрийн бүсэд тарихад тохиромжтой.

Тариалалт

Тариалалтыг хаврын эхэн үе буюу 4-р сарын сүүлчээс 5-р сарын эхний 10 хоногт хийх нь хамгийн тохиромжтой. Энэ үед хөрс бүрэн гэсэж, модны ургалт идэвхиждэг. Нарны гэрэл сайн тусдаг, задгай газар сонгох нь зүйтэй. Хайлаас нь гэрэлд дуртай тул сүүдэрт ургалт удааширдаг. 1-2 настай, үндэсний систем нь сайн хөгжсөн, эрүүл суулгац сонгох нь чухал.

Амьд хашлаганы зориулалтаар тариалах бол 40 см гүн, 30 см өргөн шуудуу ухна.

Ганц мод хэлбэрээр тариалах бол үндэснээс 2-3 дахин том (60х60х60 см) нүх ухах шаардлагатай.

Ухсан хөрсийг ялзмагтай хольж бэлтгэх бөгөөд ялзмаг байхгүй тохиолдолд үнс эсвэл органик бордоо (сайн ялзарсан бууц)-г 1:1 эсвэл 1:2 харьцаатай хольж бэлтгэнэ. Суулгацыг нүхэнд суулгахдаа үндэсний хүзүүвч (иш үндэстэй нийлэх хэсэг) нь газрын түвшинтэй тэнцүү эсвэл 1-2 см дор байхаар суулгана. Хэт гүн тарихыг хориглоно.

Хөрсийг нүхэнд хийж, хөнгөн дарж нягтруулсны дараа анхны усалгааг хангалттай хийж, хөрсөн дэх агаарыг гаргана. Дараа нь модны суурийг тойруулан сүрэл, модны үртэс зэрэг органик материалаар 5-10 см зузаантай хучих нь чийг хадгалах, хогийн өвс ургахаас хамгаална. Анх үндэслэсний дараа нэмэлт усалгаа бага шаарддаг. Хөрсний үржил шим, хүчиллэг чанарт өндөр шаардлага тавьдаггүй.



Арчилгаа

Хайлаасыг амьд хашлага, салхины хамгаалалтын зурвас хийх, тариалангийн талбайг салхинаас хамгаалах болон хот суурин газрын ногоон байгууламж байгуулах зорилгоор ихэвчлэн тариалдаг. Өрхийн нөхцөлд амьд хашлага болгон ашиглахад хурдан ургаж, тайралт сайн даадаг тул салхи, тоос шорооноос хамгаалсан ногоон хашлага байгуулахад нэн тохиромжтой. Арчилгаа бага шаарддаг ч амьд хашлага хэлбэрээр ургуулахад жилд 1-2 удаа тайралт хийж, хэлбэржүүлэн өтгөрүүлэх шаардлагатай.

4.3 АМЬД ХАШЛАГАТАЙ БОЛОХОД ХАМГИЙН ТОХИРОМЖТОЙ СОНГОЛТУУД

Налайх дүүргийн эрс тэс уур амьсгал, хуурай хөрс болон салхи, тоосжилт ихтэй нөхцөлд амьд хашлага хийхийн тулд хамгийн гол нь хүйтэнд тэсвэртэй, тайралт даадаг бөгөөд өтгөн ургадаг мод сонгох хэрэгтэй.

Та өөрийн амьдарч буй орчин нөхцөлдөө тохируулан дараах моддоос сонголтоо хийгээрэй. Налайхын нөхцөлд амьд хашлага хийхэд тохиромжтой мод, бут сөөгийг танилцуулъя.

№	Сорт	Давуу Тал	Сул Тал
1	Шар хуайс	Хамгийн тэсвэртэй. Хүйтэн (-45°C), ган, муу хөрсөнд бүрэн тэсвэртэй. Азот бэхжүүлж хөрсийг сайжруулна. Тайралт маш сайн дааж, нягт ургана.	Хурдан ургадаг тул тогтмол тайралт хийх шаардлагатай. Хавар богино хугацаанд цэцэглэдэг.
2	Хайлаас	Маш хурдан ургана. Салхи, тоосжилт, хотын бохирдолд тэсвэртэй. Тайралт сайн даадаг тул хэлбэржүүлэхэд хялбар.	Хурдан ургадаг тул жилд 2-3 удаа тайралт хийхгүй бол хэлбэрээ алддаг.
3	Голт бор	Хүйтэнд тэсвэртэй, маш үзэсгэлэнтэй, анхилуун үнэртэй цэцэгтэй. Цэцэглэлтийн дараа тайралт хийхэд өтгөн ургана.	Тайралт хийхгүй бол зарим сорт нь бусдыгаа бодвол арай удаан ургадаг.
4	Нохойн хошуу	Хүйтэн, ганд тэсвэртэй. Жимс нь ашиг тустай. Өргөстэй тул хамгаалалтын үүрэг гүйцэтгэнэ.	Хэлбэржүүлэн тайрах нь ажиллагаа ихтэй (өргөстэй). Нэг хэлбэрт оруулахад амаргүй.
5	Хайлаас	Маш хурдан ургана. Салхи, тоосжилт, хотын бохирдолд тэсвэртэй. Тайралт сайн даадаг тул хэлбэржүүлэхэд хялбар.	Хурдан ургадаг тул жилд 2-3 удаа тайралт хийхгүй бол хэлбэрээ алддаг.



4.4 АМЬД ХАШЛАГА ХИЙХ АРГАЧЛАЛ

Шар хуайс нь азот бэхжүүлж, хөрсийг сайжруулдаг. Ган, хүйтэнд гайхалтай тэсвэртэй тул Налайхын эрс тэс уур амьсгалтай нөхцөлд хамгийн тохиромжтой сонголт юм.

Та өөрийн амьдарч буй орчиндоо амьд хашлага хийхдээ эхлээд хашлага хийх газрынхаа нийт уртыг хэмжинэ. Хэрвээ өтгөн, шигүү хашлага хийхийг хүсвэл 1 метр уртад 8-10 ширхэг суулгац тарина гэж тооцно. (Жишээ нь: 10 метр хашаанд 80-100 суулгац)

Үндэслэх чадвар хамгийн өндөр. Хавар 4 дүгээр сарын сүүлчээс 5 дугаар сарын эхээр модоо тарина.

№	Алхам	Аргачлал
1	Шуудуу ухах	Хашаа татах чиглэлээр 40 см гүн, 30 см өргөн шуудуу ухна.
2	Хөрс сайжруулах	Шар хуайс ямар ч хөрсөнд ургадаг ч яг тарих нүхэндээ (шуудуундаа) бага зэрэг органик бордоо (ялзмаг эсвэл сайн ялзмагжсан бууц) нэмж өгөх нь эхний ургалтыг түргэсгэнэ.
3	Суулгац тарих	Бэлтгэсэн шуудуундаа суулгацуудыг 10-12 см-ийн зайтай нягт байрлуулна. Суулгацын үндэсний хүзүүвч нь газрын түвшинтэй тэнцүү байхаар эсвэл 2-3 см гүнд орохоор тарина.
5	Нягтруулах	Хөрсөөр хучиж, хөнгөн дарж нягтруулна. Дараа нь анхны усалгааг хангалттай хийж (шуудууг дүүргэж), үндсийг бэхэлнэ.
6	Хөрс хучих	Шуудууны дагуу сүрэл, модны үртэс эсвэл хайргаар хучих нь чийгийг хадгалж, хогийн өвс ургахаас сэргийлнэ.
7	Усалгаа	Эхний жил модыг үндэслэх хүртэл 7-10 хоногт 1 удаа усална. Шар хуайс үндэслэсний дараа (2-3 жил) Налайхын нөхцөлд нэмэлт усалгаа бараг шаардлагагүй болно.
8	Тайралт	Эхний жилд оройг нь бага зэрэг тайрч, ургалтыг дэмжинэ. Хоёр дахь жилээс эхлэн жилд 1 удаа буюу хаврын эхэнд тайралт хийж, трапец хэлбэрт оруулна (доод хэсэг нь дээд хэсгээсээ өргөн). Энэ нь хашааг нягт, шигүү болгоно.
9	Өвөлжилт	Тусгай хамгаалалт шаардлагагүй. Шар хуайс Монголын хүйтэнд бүрэн тэсвэртэй.
10	Нөхөн тарилт	Хатаж үхсэн эсвэл ургаагүй суулгацыг дараагийн хавар нь нэн даруй нөхөж тарина.

Төмөр хашаа зэвэрч, модон хашаа өмхөрдөг бол амьд хашлага жил ирэх тусам томорч, үнэ цэн нь нэмэгддэг. Утаа, тоосжилтоос ангид байх хамгийн энгийн бөгөөд ухаалаг шийдэл бол “амьд хашлага” юм.

“Хашаандаа мод тарьж хайртай бүхнээ хамгаалцгаая!”

АЖЛЫН ХУУДАС-4

СЭДЭВ 4. ӨРХИЙН НӨХЦӨЛД ТАРИХ БОЛОМЖТОЙ МОД

I. ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨЛТ

Асуулт 1: Танай хашаа, орчинд тарихад тохиромжтой 2 мод, бут сөөгийг нэрлэнэ үү?

.....

Асуулт 2: Эдгээр модыг сонгосон шалтгаанаа бичнэ үү. (Жишээ нь: Салхинаас хамгаалах, гоё харагдах, жимс авах, арчилгаа бага гэх мэт)

.....

II. УХААЛАГ СОНГОЛТ

Төрөл	Онцлог ба ач тус	Тохиромжтой байршил
Шар хуайс	Хурдан ургадаг, мал, амьтнаас хамгаалсан өргөстэй, "Амьд хашлага" болоход хамгийн тохиромжтой.	Хашааны гадна
Хайлаас	Утаа, тоосжилтыг сайн шүүдэг, хэлбэржүүлэхэд хялбар, маш тэсвэртэй.	Хашааны дагуу, замын талд
Голт бор	Үзэсгэлэнтэй цэцэгтэй, анхилуун үнэртэй, орчныг тохижуулна.	Байшингийн урд, цонхны дор
Үхрийн нүд	Гэр бүлийн хэрэгцээнд экологийн цэвэр жимс өгнө. Арчилгаа их шаардахгүй.	Нар сайн тусах хэсэгт.

III. МИНИЙ АМЛАЛТ

Би өөрийн амьдарч буй орчиндоо ногоон байгууламжийг нэмэгдүүлж, хуучин хашаагаа амьд хашлагаар сольж чадна. Ингэхийн тулд би өнөөдрөөс мод тарих, ургуулах, арчлах аргад идэвхийлэн суралцаж, ӨӨРЧЛӨЛТИЙГ ӨӨРӨӨСӨӨ ЭХЛҮҮЛЭХ болно гэдгээ амлаж байна.

Налайх дүүргийн ... дүгээр хорооны оршин суугч

..... овогтой

202... оны сарын -ний өдөр

Гарын үсэг

.....

**Модноос
ашиг хүртэх
боломжууд**



5.1 МОДНЫ СУУЛГАЦ ҮРЖҮҮЛЖ ХУДАЛДААЛАХ БОЛОМЖ

Модны суулгац үржүүлж худалдаалах нь байгаль орчинд ээлтэй төдийгүй урт хугацаанд тогтвортой ашиг авчрах бизнес юм. Монгол улсад “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн өрнөж буйтай холбоотойгоор суулгацын эрэлт хэрэгцээ 2025 оны байдлаар маш өндөр байна.

Суулгац үржүүлэх үндсэн аргууд

Суулгацыг дараах 3 аргаар үржүүлж, борлуулах боломжтой.

Үрээр тарих- Хамгийн бага зардлаар их хэмжээний суулгац гаргах арга. (Жишээ: Нарс, шинэс)

Мөчрөөр үржүүлэх - Модны мөчрийг огтолж, үндэслүүлэн суулгах. (Жишээ: Улиас, бургас, хайлаас)

Үндэсний болон бутны хуваалт - Чацаргана, үхрийн нүд зэрэг бут, сөөгийг хуваах замаар үржүүлэх.

Суулгацын зах зээлийн дундаж үнэ (2025 он)

Үнэ нь суулгацын өндөр, нас, төрөл болон үндэсний систем (ил үндэстэй эсвэл бортоготой) зэргээс хамаарч харилцан адилгүй байдаг.

Модны төрөл	Нас / Өндөр	Үнэ
Шинэс (Ларкс)	2-3 настай (30-50 см)	5,000₮ - 15,000₮
Нарс	3-5 настай (50-100 см)	15,000₮ - 45,000₮
Хайлаас	2 настай (50-80 см)	1,500₮ - 3,500₮
Шар хуайс	2 настай	2,000₮ - 4,000₮
Чацаргана	2 настай (сортын)	5,000₮ - 12,000₮

Хэрэв та “Амьд хашлага” төсөлд зориулж 100-аас дээш суулгац худалдан авбал үржүүлгийн газрууд 10-20%-ийн хөнгөлөлт үзүүлдэг. Хэрэв таны “Ногоон Аж Ахуй” төсөл нь дүүргийн ЗДТГ эсвэл ТББ-ын дэмжлэгтэй бол хөнгөлөлттэй үнээр суулгац авах боломжтой.

Өөрөө үржүүлэх

Хайлаас болон шар хуайсыг хашаандаа үндэсний найлзууруудаар үржүүлэн гаргавал нэгжийн өртөг нь 500₮-өөс хэтрэхгүй болж, таны ашиг 150% хүртэл нэмэгдэнэ.

Хэрэв та суулгац үржүүлгийн бизнес хийх гэж байгаа бол дараах зүйлс үнэд шууд нөлөөлнө:

- Модыг бортогонд (саванд) ургуулж зарвал амьдрах чадвар нь 95% байдаг тул ил үндэстэй суулгацаас 2-3 дахин өндөр үнээр зарагддаг.

- Налайх дүүргийн эрс тэс уур амьсгалд дасан зохицсон, “хүйтэнд тэсвэртэй” суулгац илүү эрэлттэй.
- Суулгацаа зарахаас гадна “Суулгацыг тарьж өгөх + 1 жилийн арчилгааны зөвлөгөө” гэсэн багц гаргаж, мөнгө олох боломжтой.

Борлуулалтын сувгууд

- “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд орон нутгийн засаг захиргаа, уул уурхайн компаниудтай гэрээ байгуулах.
- Шинэ орон сууцны хорооллын тохижилт хийж буй компаниудад нийлүүлэх.
- Хашаандаа мод тарих хүсэлтэй айл өрхүүдэд сошиал медиа (Facebook, Marketplace) ашиглан шууд борлуулах.

Хэрэв та 1000 ширхэг хайлаасны суулгацыг мөчрөөр үржүүлж, 2 жилийн дараа тус бүрийг 3000₮-өөр борлуулвал 3,000,000₮ олох боломжтой. Үүнд орох зардал нь маш бага (ус, бага зэрэг бордоо, хөдөлмөр) байдаг.

5.2 ЖИМСНИЙ МОДНООС АШИГ ХҮРТЭХ БОЛОМЖ

Хашаандаа тарьж ургуулсан модноос эдийн засгийн ашиг хүртэх боломжтой бөгөөд хүрээлэн буй орчноо эрүүл болгох, амьдралын чанар сайжрах зэрэг давуу талтай. Хамгийн чухал нь байгальд ээлтэй, эрүүл амьдралын хэв маягийг дэмжиж, өрхийн амьжиргаагаа дээшлүүлж, орон нутгийн эдийн засагт бодит хувь нэмэр оруулах боломж бүрддэг. Өөрийн тарьж ургуулсан модноос дараах байдлаар ашиг шим хүртэх нь зөвхөн орлого олох төдийгүй өрхийн гишүүдийг байгальд ээлтэй амьдралын хэв маягт уриалах ач холбогдолтой.

Жил бүрийн тариалалтаар ахуйн хэрэгцээнээс илүү гарч буй жимс, жимсгэнийг түүж худалдах эсвэл боловсруулан нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн (жимсний чанамал, хатаасан жимс, тос, цай) болгон борлуулах боломжтой. Ялангуяа чацаргана, нохойн хошуу зэрэг жимс нь С витаминаар баялаг, эрүүл мэндэд тустай тул зах зээлд эрэлт өндөр.

Үзүүлэлт	Түүхий жимс (кг-аар)	Боловсруулсан (1 литр шүүс/тос)
Дундаж үнэ (2025 он)	4,000 – 6,000 ₮/кг	Шүүс: 8,000 – 15,000 ₮/л; Тос: 40,000 – 80,000 ₮/л
Нэг бутнаас авах ургац	5 – 15 кг (5-8 настай бут)	
Үндсэн зардал	Усалгаа, арчилгаа, түүх зардал.	
Худалдаалах ашиг	Түүхий жимс: Нийт орлогын 40%–60% нь ашиг байх боломжтой (Хэрэв өөрөө түүвэл).	Боловсруулсан жимс: Орлогын 60%–80% нь ашиг байх боломжтой (Тогоо, сав, баглаа боодлын зардлыг хассаны дараа).
Ашиг нэмэгдүүлэх	Жимсээ чанартай (том, бүрэн боловсорсон) түүж, шууд хэрэглэгчдэд худалдах.	

Тарьж ургуулсан модноос ялангуяа, жимсний бут сөөгнөөс ашиг хүртэх нь өрхийн эдийн засагт томоохон дэмжлэг болдог. Монгол орны эрс тэс уур амьсгалд дасан зохицсон чацаргана, нохойн хошуу, үхрийн нүд зэрэг нь амин дэмээр баялаг тул зах зээлд үнэ цэнтэй бүтээгдэхүүн болдог.

Борлуулалтын үндсэн сувгууд

Монголын жижиг, дунд үйлдвэрлэгч болон өрхийн тариаланчдад дараах борлуулалтын сувгууд хамгийн нээлттэй байдаг.

- Орон нутгийн зах болон “Нарантуул”, “Барс” зах: Шинэ ургацын үеэр жимсийг түүхийгээр нь борлуулах хамгийн хялбар арга.
- Сошиал медиа (Facebook групүүд): “Налайхын зар”, “Эрүүл хүнс”, “Өрхийн тариаланчид” зэрэг групүүдээр дамжуулан шууд хэрэглэгчдэд (зуучлагчгүйгээр) хүргэж өгөх замаар илүү өндөр ашиг олох боломжтой.
- Үзэсгэлэн худалдаа: Жил бүр зохион байгуулагддаг “Намрын ногоон өдрүүд”, “Монголд үйлдвэрлэв” зэрэг үзэсгэлэнгүүдэд оролцож бүтээгдэхүүнээ танилцуулах.
- Налайх дүүрэгт зохион байгуулагддаг “Алтан намар” үзэсгэлэн болон өрхийн үйлдвэрлэгчдийн задгай талбайн худалдаанд оролцох боломжтой.

Нэмүү өртөг шингээх боломжууд

Түүхий жимсийг шууд худалдахаас илүүтэй боловсруулж худалдсанаар ашиг нь 2-3 дахин нэмэгддэг.

Чацаргана жимсний шүүс, охь нь хамгийн эрэлттэй бүтээгдэхүүн. Мөн чацарганы тос нь гоо сайхан болон эмчилгээний зориулалтаар маш өндөр үнээр зарагддаг (100 мл тос гаргаж авахад их хэмжээний үр ордог тул үнэ цэн ихтэй). Үүнээс гадна чацаргана жимсний шүүсийг авсны дараа үлдэх шаарыг хатааж “Чацарганы цай” болгон савлаж зарах боломжтой.

Нохойн хошуу жимсний хатаасан үрийг өвлийн улиралд С витаминэ эх үүсвэр болгон борлуулахад тохиромжтой. Мөн нохойн хошууны сиропыг дархлаа дэмжих бэлдмэл болгон савлаж худалдан ашиг олох боломжтой.

5.3 ӨРХИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ ТӨСЛҮҮД

Жижиг, дунд үйлдвэрлэлийн газар болон банк, банк бус байгууллагуудын зээлийн шалгуур (барьцаа хөрөнгө, орлого нотлох баримт) өндөр байдаг нь өрхийн тариаланчдад томоохон бэрхшээл болдог. Иймд өрхийн үйлдвэрлэлийг хамгийн сайн дэмждэг, хөнгөлөлттэй нөхцөл бүхий дараах төслүүдийг анхаарахыг зөвлөж байна.

1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн төслүүд

Дүүргийн ХХҮХ-ээс жил бүрийн хавар, намар зарлагддаг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн төслүүдэд хамрагдах нь банкны зээлээс хамаагүй хялбар бөгөөд давуу талтай.

Зээлийн хэмжээ: 3,000,000 - 10,000,000 төгрөг (Үйлдвэрлэл, тариалалтын цар хүрээнээс хамаарч хэмжээ нь өөр байна).

Хугацаа: Ихэвчлэн 24-36 сар.

Давуу тал: Хүүгүй эсвэл маш бага хүүтэй, барьцаа хөрөнгө бага шаарддаг, эргэн төлөлтийн уян хатан нөхцөлтэй (Жишээ нь: Эхний 6 сар үндсэн төлбөрөөс чөлөөлөх).

Төсөлд хамрагдахад анхаарах зүйлс

Төсөл бичих- Та ямар төрлийн мод, суулгац үржүүлэх, түүнийгээ хаана борлуулах, үйл ажиллагаагаа хэрхэн өргөжүүлэхээ тодорхой тусгасан жижиг төсөл бичих шаардлагатай.

Сургалтад хамрагдах- ХХҮХ-ээс зохион байгуулдаг “Бизнес эрхлэлтийн сургалт”-д сууж сертификат авсан байх нь давуу тал болно.

Бүртгэл- Өөрийн харьяа хорооны “Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн”-тэй уулзаж, төслийн хугацааг урьдчилан тодруулах.

Хэрвээ та урьд өмнө нь төсөл бичиж байгаагүй болон төсөл бичих аргачлалыг сайн мэдэхгүй байвал Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хандаж, төсөл бичих бэлэн загвар авах боломжтой. Мөн төсөл хэрхэн бичих тухай зөвлөгөө, мэдээллийг Налайх дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн мэргэжилтнээс тодруулж, сайжруулалт хийх арга зүйн зөвлөгөө авч болно.

Таны материал эхний шатанд тэнцсэн тохиолдолд Налайх дүүргийн Насан туршийн суралцахуйн төвөөс Бизнес санаа хөгжүүлэх, төсөл боловсруулах сургалт /өмнөх/ болон таныг төслийн дэмжлэгийг авсны дараа Бизнес эрхлэх ур чадварын (жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсны дараах) сургалтуудад тус тус хамруулах болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хаягаар тодруулах боломжтой.

Налайх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс	Налайх дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв	Налайх дүүргийн Насан туршийн суралцахуйн төв
		
		

Та өрхийн үйлдвэрлэлээ эхлүүлэхдээ эхнээс нь бичиг баримт, санхүүгийн зардлуудаа эмх цэгцтэй хадгалж, борлуулалт бүрийг өөрийн дансандаа оруулж, төслийн шалгуураа хангахад анхаарлаа хандуулж ажиллаарай.

Танд амжилт хүсье.

5.4 ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ САНААЧИЛГАД НЭГДЭЖ, УРАМШУУЛАЛД ХАМРАГДАХ БОЛОМЖ

“Тэрбум мод таны хашаанаас эхэлнэ” санаачилгын хүрээнд иргэн та өөрийн тарьсан модыг хэрхэн бүртгүүлж, урамшуулал авах болон тарьсан модоо технологиор хэрхэн баталгаажуулах тухай дэлгэрэнгүй заавар, мэдээллийг нэгтгэн бэлтгэлээ.

Цахим бүртгэлд хамрагдах заавар

Иргэн та хашаандаа мод тарьсан бол дараах алхмуудын дагуу бүртгүүлж, “Ногоон дата” болон “Карбон кредит”-ийн эзэн болох боломжтой.

Бүртгэл хийх- terbummod.mn вэбсайт эсвэл E-Mongolia аппликэйшний “Миний хашаанд-Тэрбум мод” цэс рүү нэвтэрнэ.

Зураг болон байршил илгээх - Модоо суулгасны дараа тухайн цэгт очиж, аппликэшнээр дамжуулан модныхоо зургийг авч илгээнэ. Энэ үед утасны GPS ашиглан модны байршлыг автоматаар баталгаажуулна.

Модны ургалтын түүх үүсгэх- Сар бүр модныхоо ургалтын явцын зургийг шинэчлэн оруулснаар таны мод “амьд” байгааг систем баталгаажуулна.

Урамшууллын тогтолцоо

Модоо амжилттай ургуулж буй иргэдийг дараах байдлаар урамшуулж байна.

1. “Ногоон дата” урамшуулал

Харилцаа холбооны оператор компаниуд (Mobicom, Unitel, Skytel, G-Mobile) таны бүртгүүлсэн модны тоо болон ургалтын явцад үндэслэн сар бүр урамшууллын датаг таны дугаарт олгоно. Урамшууллыг авахын тулд та сар бүр модныхоо зургийг шинэчлэн илгээж, ургалтыг нь баталгаажуулсан байх ёстой.

2. Карбон кредит (Ногоон оноо)

Мод ургаж, навч гарч эхлэх үед агаар дахь нүүрстөрөгчийг шингээх чадвар нь нэмэгддэг. Систем нь хиймэл оюун ухаан (AI) ашиглан таны мод хэдий хэмжээний CO₂ шингээж байгааг тооцоолж, түүнийг нь мөнгөн дүнтэй дүйцэхүйц оноо болгон таны цахим хэтэвчинд хуримтлуулна.

Налайх дүүргийн иргэд та бүхнийг энэхүү цахим бүртгэлд идэвхтэй оролцож, дүүргээ ногоон болгохын зэрэгцээ технологийн урамшууллаа авахыг уриалж байна.

Технологийн хяналт

Таны илгээсэн мэдээллийг технологийн дараах шийдлээр хянаж, баталгаажуулдаг.

Дрон хяналт: Дүүргийн хэмжээнд дроноор тогтмол нислэг хийж, айл бүрийн хашаанд бүртгэгдсэн моддын өндөр, титмийн хэмжээ, навчны ногоон байдлыг (NDVI индекс) хянана.

AI зураг боловсруулалт: Таны илгээсэн зургийг хиймэл оюун ухаан шинжилж, модыг жинхэнэ эсвэл хиймэл (хуванцар) болохыг, мөн өвчлөл байгаа эсэхийг тогтоодог.

Иргэн та хашаандаа мод тарьж ногоон орчныг бүрдүүлээд зогсохгүй, “ногоон бизнес”-ээр дамжуулан орлого олох боломжтой.

АЖЛЫН ХУУДАС-5

СЭДЭВ-5 МОДНООС АШИГ ХҮРТЭХ БОЛОМЖУУД

I. МОДНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭ ЦЭН

Асуулт 1. Мод тарьснаар таны гэр, орчинд ямар эерэг өөрчлөлт авчирна гэж бодож байна вэ?

.....

.....

Асуулт 2. Иргэд хамтран мод тарихын ач холбогдол юу вэ?

.....

.....

II. МОДНЫ ШУУД БУС АШИГ ТУС

Доорх 2 баганыг хооронд нь зөв харгалзуулаарай.

Ашиг тус	Тайлбар
А. Дуу чимээ намсгах	1. Хөрсний чийгийг барьж, гүний усыг хамгаална.
Б. Усны эргэлт	2. Навч нь замын болон үйлдвэрийн шуугианыг шингээдэг.
В. Сэтгэл зүйн эрүүл мэнд	3. Ногоон өнгө нүд амрааж, стрессийн дааврыг бууруулдаг.
Г. Агаарын чийгшил	4. Мод нь ууршилт явуулж, зуны халуун өдөр орчныг сэрүүцүүлдэг.

III. МИНИЙ УРИА

Та өөрийн хөршүүд болон найз нөхдөдөө хандан “Мод тарихын эдийн засгийн ашиг тус”-ыг сурталчилсан уриалга бичээрэй. Тухайн уриалгыг өөрийн цахим хуудсаар дамжуулан хөршүүддээ болон танил, найзууддаа түгээгээрэй.

.....

.....

III. ТЭМДЭГЛЭЛ /САНАЛ ХҮСЭЛТ (Энэхүү гарын авлагатай холбоотой саналаа бичнэ үү.)

.....

.....

ӨӨРЧЛӨЛТИЙГ ӨӨРӨӨСӨӨ ЭХЛҮҮЛЖ, ҮР ХОЙЧДОО НОГООН ИРЭЭДҮЙГ ӨВЛҮҮЛЭН
ҮЛДЭЭХ ЭРХЭМ ТАНД АМЖИЛТ ХҮСЬЕ.

ХАВСРАЛТ-1

МОД ТАРЬСАН ТЭМДЭГЛЭЛ

№	Модны нэр, төрөл	Тарьсан огноо	Арчилгаа хийсэн тэмдэглэл

Анхаарах зүйлс:

.....

.....

ХАВСРАЛТ-2

МОД АРЧИЛГААНЫ ХУАНЛИ

АРЧИЛГАА	1 дүгээр 7 хоног	2 дугаар 7 хоног	3 дугаар 7 хоног	4 дүгээр 7 хоног
УСАЛГАА				
МАНАЛТ				
БОРДОХ				
ХУЧЛАГА				
ТАЙРАЛТ				
ШАВЖНЫ УСТГАЛ				
ХӨРС СИЙРЭГЖҮҮЛЭХ				

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

Энэхүү гарын авлагад ашигласан болон цаашид мэдлэг ойлголтоо нэмэгдүүлэх илүү өргөн хүрээнд судлахад шаардагдах ном, сурах бичиг, судалгааны материалууд болон олон улсын тайлан, тайлбаруудыг дор жагсаасан болно.

1. С.Эрдэнэсүх, (2022). Уур амьсгалын өөрчлөлт түүнд дасан зохицох нь сургалтын гарын авлага, Улаанбаатар.
2. Хүүхдийг Ивээх Сан. (2025). Уур амьсгалын өөрчлөлт ба байгаль орчны боловсрол. Улаанбаатар.
3. Нэгдсэн Үндэсний Байгууллага, Эмнести Интернэшнл (2020). Хүний эрхийг хангах амлалтаа биелүүлэх нь сургалтын гарын авлага. Улаанбаатар.
4. Г. Даваадорж, Монгол ногоо төсөл (2016). Гэр бүлээрээ хамтран ажиллацгаая гарын авлага. Улаанбаатар.
5. Д. Энэбиш. (2007) Амьдрах ухаанд суралцах бичиг. Улаанбаатар.
6. Д. Даваадорж. (2019). Хөрс судлал. Улаанбаатар.
7. Д. Дагвадорж. (2019). Уур амьсгалын өөрчлөлт ба Монгол орон: Сорилт, боломж. Улаанбаатар.
8. Б. Жамбажамц. (2021). Цөлжилт ба газрын доройтлыг бууруулах арга технологиуд. Шинжлэх ухааны академи, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн.
9. Ж. Чогдон. (2022) Монгол орны ойжуулалт, ойг нөхөн сэргээх технологийн зааварчилгаа. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл.
10. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP). (2022). Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутгийн хөгжил: Сургагч багшийн гарын авлага.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУАНЛИ

<p>Гуравдугаар сарын 21</p> <p>Дэлхийн ойн өдөр</p> <p>Энэ өдөр ойн санг хамгаалах, мод тарихыг уриалах зорилготой.</p>	<p>Гуравдугаар сарын 22</p> <p>Дэлхийн усны өдөр</p> <p>Ус, түүний ач холбогдол, хүн төрөлхтөнд тулгарч буй хамгийн том асуудал буюу цэвэр усны хомсдолын талаар олон нийтэд ойлгуулах өдөр.</p>	<p>Гуравдугаар сарын сүүлчийн 7 хоногийн бямба гараг</p> <p>Эх дэлхийн цаг</p> <p>Дэлхийн дулаарлын гол шалтгаануудын нэг болсон хүлэмжийн хийг бууруулахад хувь хүний оролцоо чухал гэдгийг сануулах зорилготой. Энэ өдөр 60 минут бүх гэрэлтүүлгээ унтрааж, эх дэлхийдээ амсхийх чөлөө өгөхийг сануулахаас гадна байгаль дэлхийгээ бүхэлд нь хамгаалахад уриалах зорилготой.</p>
<p>Дөрөвдүгээр сарын 22</p> <p>Эх дэлхийн өдөр</p> <p>Хүн төрөлхтний зүгээс эх дэлхийд учруулж байгаа байгаль орчны хор хохирлыг анхаарлын төвд оруулах зорилготой.</p>	<p>Тавдугаар сарын 3</p> <p>Нарны өдөр</p> <p>Энэ өдөр сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах боломжийг сурталчлах, үүнд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилготой.</p>	<p>V, X дугаар сар 2 дахь долоо хоногийн бямба гараг</p> <p>Мод тарих үндэсний өдөр</p> <p>Цөлжилт, ган, зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамжийг бага ч гэсэн бууруулж, эх дэлхийгээ хэвээр нь авч үлдэхэд мод тарих нь чухал болохыг сурталчилж, бүх нийтээр мод тарих зорилготой.</p>
<p>Зургаадугаар сарын 17</p> <p>Дэлхийн цөлжилттэй тэмцэх өдөр</p> <p>Энэ өдөр цөлжилт, ган гачиг, газрын доройтлын хор уршгийг таниулах, тэмцэх, нөхөн сэргээхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэдэг. Монгол улс 1996 онд уг конвенцид нэгдсэн бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 77 орчим хувь нь цөлжилтөд нэрвэгдээд байгаа юм.</p>	<p>10 дугаар сарын 6</p> <p>Дэлхийн амьдрах орчны өдөр</p> <p>Энэ өдрийг ДЭЛХИЙ дан ганц хүний амьдрах орчин биш, бусад амьд байгаль, ан амьтны өлгий мөн тул хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй ямар их аюул учирдаг болохыг тэдэнд ухааруулах зорилгоор тэмдэглэдэг.</p>	<p>10 дугаар сарын 13</p> <p>Байгалийн гамшгийг бууруулах олон улсын өдөр</p> <p>Энэ өдөр байгалийн гамшиг болох үер, хар салхи, ган, зуд зэргийн гамшиг тохиолдож буй шалтгаан, хүний буруутай үйл ажиллагаа, гамшгийн үр дагаврыг таниулж, шийдвэрлэх арга замыг хэлэлцэх, олон нийтэд ойлгуулах зорилготой.</p>



Save the Children

Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан

📍 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

Аризона төв, 4-р давхар

☎️ +976-11-329365, +976-11-329371

📠 +976-11-329361

✉️ mongolia.secretary@savethechildren.org

🌐 www.savethechildren.mn

📘 Save the Children in Mongolia

📱 Save the Children MN

📷 [Savethechildren.mongolia](https://www.instagram.com/Savethechildren.mongolia)